МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2021 оны 01 сарын 14 өдөр Дугаар A/07 Улаанбаатар хот

Хөтөлбөр, төлөвлөгөө батлаж,
хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, 28.1.4, 28.1.6, 28.1.7 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.8 дах зорилт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 06-ны өдрийн хуралдааны 2 дугаар тэмдэглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөрийг нэгдүгээр, төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт ёсоор батлсугай.

2. Чадварлаг багш арга хэмжээний хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох дарга нарт даалгасугай. Үүнд:

2.1. Шинэ зууны Монгол багшийн загвар, багшийн мэргэжлийн стандарт, багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг боловсруулж, 2021 оны эхний хагас жилд багтаан батлуулах арга хэмжээ авах, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулахыг Дээд боловсролын газар /Г.Батнэмэх/, Монгол Улсын Боловсролын их сургууль /Д.Мандах/-д;

2.2. Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, урамшуулал тооцох аргачлал боловсруулж, 2021 оны 1 дүгээр улиралд багтаан батлуулахыг Стратеги, бодлого төлөвлөлтийн газар /Ж.Ганбаатар/, Санхүү, эдийн засгийн газар /С.Нансалмаа/-т;

2.3. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулга, хэлбэр, арга замыг багшийн мэргэжлийн стандартад нийцүүлэн зохион байгуулах, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд зөвлөх багш сургалтыг нэвтрүүлж ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/-д;

2.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага, багш нарт хөтөлбөр, төлөвлөгөөг таниулах сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институт /Ж.Болормаа/, аймаг, нийслэлийн Боловсрол, соёл, урлагийн газрын дарга нарт;

2.5. Арга хэмжээний хэрэгжилт, зохион байгуулалтыг нэгдсэн удирдлагаар хангаж, хагас жил тутамд тайлагнаж ажиллахыг Сургуулийн өмнөх боловсролын газар /Ж.Мягмар/, Бага, дунд боловсролын газар /Т.Ням-Очир/-т;

1420100298

2.6. Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусган батлуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд /Г.Ганбаяр/, Санхүү, эдийн засгийн газар /С.Нансалмаа/, Хөрөнгө оруулалтын газар /Ч.Энх-Амгалан/-т;

2.7. Хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ үнэлгээ хийж, сайжруулах зөвлөмж, чиглэл өгч ажиллахыг Хяналт, үнэлгээ дотоод аудитын газар /Г.Энхжаргал/-т;

3. Энэ тушаалын хэрэгжилтийг чанартай, хугацаанд нь гүйцэтгүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд /Г.Ганбаяр/-т даалгасугай.

САЙД Л.ЦЭДЭВСҮРЭН

*Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн А/07 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт*

# "ЧАДВАРЛАГ БАГШ" АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР, ТӨЛӨВЛӨГӨӨ

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Боловсролын салбарт бодит хувь нэмэр оруулах, өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх чадвартай, багшид ажлын байранд тогтвортой суурьшилтай ажиллаж, тасралтгүй хөгжих нөхцөл бүрдүүлэх нь боловсролын шинэчлэлийн нэн чухал асуудал билээ. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих бодлогыг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдэд тусган хэрэгжүүлж иржээ. Тухайлбал, "Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль (2018)"-д багшийн хөгжлийг дэмжих тогтолцоо бүрдүүлэх, багшийн хөгжлийн хөтөлбөрийг батлуулж хэрэгжүүлэх, багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан урамшуулал олгох, "Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)"-д боловсролын үйлчилгээ олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц чанартай, хүртээмжтэй байх, багш бэлтгэх сургалтын байгууллагын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулах, багшийн хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоо бүрдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэх, "Боловсрол үндэсний хөтөлбөр (2010-2021)"-д багш бэлтгэх хөтөлбөр, багш боловсролын стандартыг шинэчлэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих асуудлыг тус тус тусгажээ.

Түүнчлэн Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого "Алсын хараа 2050", УИХ-аар 2020 онд батлагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 209 дүгээр тогтоолоор батлагдсан Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөртэй уялдуулж, багш бэлтгэх, мэргэшүүлэх сургалтыг тогтвортой хөгжлийн боловсролын зарчим, "Боловсролын салбарын дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөө (2021-2030)"-д багш мэргэжилтний тасралтгүй хөгжлийг боловсролын чанарыг сайжруулах тулгуур зорилт болгожээ. Тухайлбал суралцагчийн хөгжлийн хэрэгцээг хангасан, бүтээлч чадварлаг багшийг бэлтгэх, багшид мэргэжлийн стандартад суурилан уян хатан хэлбэрээр тасралтгүй хөгжих боломж нөхцөлийг бүрдүүлэх, түүнд нээлттэй боловсрол, дижитал технологи ашиглах зэрэг зорилт, үйл ажиллагааг төлөвлөсөн байна. "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т "Чадварлаг багш" арга хэмжээний хүрээнд эдгээр зорилт, үйл ажиллагаа ч мөн хэрэгжүүлэхээр тусгажээ.

Технологийн хурдацтай хөгжил, байгаль орчинд гарч буй өөрчлөлт, хөдөлмөрийн зах зээлийн хувьсал, хөгжлийн онцлогоос үл шалтгаалан суралцагч нь шинжлэх ухааны мэдлэг, танин мэдэхүй, нийгэмшихүй, сэтгэл хөдлөлийн чадвартай, сониуч, өөрийн суралцахуйг удирддаг, бусдын санал бодол, үнэт зүйлд хүндэтгэлтэй ханддаг, өсөлтийн сэтгэлгээтэй[1] байх шаардлагатай болж байна. Иймээс багш нар өөрсдөө мэргэжлийн мэдлэг, ур чадвартай байхаас гадна сурагчдын мэдлэг, чадвар, хандлагад гарах үр дүнд баримжаалан сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлдэг, сургалтыг удирдан чиглүүлдэг мэргэшсэн чадамжтай (expertise), тасралтгүй хөгжих хандлагатай, технологийн ололт дэвшлийг өөрөө хөгжил болон сургалтад чадварлаг ашигладаг[2], бусадтай хамтран насан туршдаа суралцаж чаддаг байх хэрэгтэй юм. Энэ мэдлэг,

[1] OECD. 2020. Learning Framework 2030
[2] OECD. 2020. Learning Framework 2030

чадвар, хандлагыг багш өөрөө, бие дааж хөгжүүлдэг байх нь хамгийн үр дүнтэй гэж үздэг бөгөөд төрийн зүгээс багш нар тасралтгүй хөгжих боломж, нөхцөлөөр хангах нь багшид чиглэсэн бодлогын тэргүүлэх зорилт болохыг олон улсын туршлага, сургамж бэлхнээ харуулж байна[3].

## ХОЁР. ЗАРЧИМ

Хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг мөрдлөг болгоно. Үүнд:

- ✓ Багшид өөрөө бие дааж хөгжих нөхцөл, насан туршдаа суралцах боломж бий болгох, дэмжлэг үзүүлэх;
- ✓ Үйл ажиллагаа нь уян хатан, нээлттэй, тогтвортой, хэрэгжихүйц байх;
- ✓ Бүх багшид мэргэжлээрээ тасралтгүй хөгжих тэгш боломж олгох;
- ✓ Багш бэлтгэх сургалт, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил нь стандартад суурилсан, эрэлт хэрэгцээнд нийцсэн байх;
- ✓ Сургууль, цэцэрлэгт суурилсан мэргэжлийн тасралтгүй хөгжилд тулгуурлах;
- ✓ Мэргэжлийн тасралтгүй хөгжилд багшийн манлайллыг хөгжүүлэх;
- ✓ Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт нь институцэд суурилсан байх;
- ✓ Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд технологийн дэвшил, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн цахим агуулгыг ашиглах;
- ✓ Төр хувийн хэвшил, төрийн байгууллагуудын түншлэл, хамтын ажиллагаа, хариуцлагад тулгуурлах зэрэг болно.

## ГУРАВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ

Энэхүү хөтөлбөр нь сургуулийн өмнөх[4], бага, дунд боловсрол болон насан туршийн боловсролын багшид мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломж, нөхцөлийг бүрдүүлэх зорилготой.

Сургалт, үйл ажиллагааны чанар, суралцагчдын сурлагын амжилт, хүмүүжил төлөвшилд бодитой ахиц гаргахад багш голлох үүрэгтэй. Багшийн мэргэжлээрээ тасралтгүй хөгжихтэй холбоотой хийгдсэн судалгаануудаас үзэхэд тэднийг төвлөрсөн байдлаар "хайрцагласан" сургалтаар хөгжүүлэх гэж оролдох нь үр дүн муутай гэдэг нь харагдаж байна. Харин ажлын ачаалал, мэргэжлийн мэдлэг, чадварын түвшин, сургалтын онцлог, нас, хүйс, туршлага, байршлаас үл хамааран бие даан хөгждөг байх нь сургалтын чанараа илүү сэдэл тэмүүлэлтэйгээр тасралтгүй сайжруулах, суралцагчийн сурах, хөгжих үйл явцыг илүү таньж мэдэх, ахиц амжилт гаргах шийдэл, арга зүйг олж мэдэхэд бодитой дэмжлэг болдог байна.

Багш мэргэжлээрээ тасралтгүй хөгжихөд дэмжлэг үзүүлэх нөхцөл боломжийг багш мэргэжлийн чиг баримжаа өгөх, багш бэлтгэх, багшаар ажиллах, илүү чадварлаг, туршлагатай багш нарын зөвлөгөө, дэмжлэг авах гэсэн 4 үе шат, мөн багш бэлтгэх сургуульд элсүүлэх, багшийг ажилд авах, тэтгэвэр тогтоож ажлаас чөлөөлөх гэсэн багшлахуйн хөгжлийн шилжилтийн 3 үндсэн төлөв байдлыг тус тус агуулсан 7 бүлэг асуудлаар тодорхойлдог байна[5]. Эдгээр үе шат, үндсэн төлөвтэй холбоотой зарим бодлогыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

[3] ЮНЕСКО. 2015. Teacher Policy development Guide
[4] Цэцэрлэгийн туслах багш нар мөн орно.
[5] АХБ, БШУЯ. (2020). СӨБ ба БДБ-ын багш, удирдах ажилтны хөгжлийн бодлого, төлөвлөгөө ба судалгааны зөвлөмжид хийсэн кластер анализын тайлан

хэрэгжүүлж ирснээс багш мэргэжлийн чиг баримжаа олгох[6], багш бэлтгэх их, дээд сургуульд элсүүлэхтэй холбоотой арга хэмжээ үр дүнтэй хэрэгжиж байна[7].

Иймээс хөтөлбөрийн зорилгыг дараах 3 чиглэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр боловсруулаад байна. Үүнд:

1. Багш бэлтгэх
2. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил
3. Багшийн ажлын нөхцөл, цалин хөлс

**Багш бэлтгэх** чиглэлээр бодлого эрх зүйн орчин, хөтөлбөрийн чанар (*багш бэлтгэдэг долоон их дээд сургуулийн 31 хөтөлбөр нь магадлан итгэмжлэгдсэн байгаа нь багш бэлтгэдэг 46 их, дээд сургуулийн 15.2 хувийг эзэлж байна, нийтдээ "багш бэлтгэх нэгдсэн хөтөлбөргүй"*), төгсөгчдийн мэдлэг, хандлага, ур чадвар (*багш бэлтгэдэг их, дээд сургуулиудын төгсөх ангийн 541 оюутан шалгалтад хамрагдсанаас 16.8 хувийн амжилттай, 0.9 хувийн чанарын үзүүлэлттэй шалгагдсан),* багш мэргэшлийн бэлтгэл, багш бэлтгэх их дээд сургуулийн сургалтын чанар, багш нарын мэдлэг, ур чадвар хангалтгүй зэрэг олон тулгамдсан асуудал[8] анхаарал татаж байна. Түүнчлэн сургалтын хөтөлбөрийн менежментийн циклийн төлөвлөлтийн дагуу сургалтын хөтөлбөрийн агуулгыг шинэчлэх үзэл баримтлал, түүнд нийцсэн сургалтын хөтөлбөр боловсруулахтай зэрэгцээд багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр, тэдгээрийг хэрэгжүүлэх багш нарын хандлага, зан чанар, сурган хүмүүжүүлэх эв дүй, харилцааны хэв маяг, заах арга барилд өөрчлөлт шинэчлэл хийх хэрэгцээ шаардлага урган гарч байна.

Ийм учраас юуны түрүүн Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, боловсролын үндсэн зорилго зэрэгт тулгуурлан XXI зууны Монгол багшийн мэргэжлийн чадамж (мэдлэг, чадвар, хандлага), үнэт зүйлийг тодорхойлсон загвартай болох шаардлагатай байна. Энэхүү загвар нь багшийн мэргэжлийн чадамжийг *шинэ багш* болон мэргэжлийн зэрэгтэй (*арга зүйч, тэргүүлэх, зөвлөх*) багшийн хувьд 4 түвшинтэй байх ба энэ нь багш мэргэжлийн чадамжаа тодорхой түвшинд баримжаалан хөгжүүлэх боломжийг олгоно. Энэ нь мөн багш карьерынхаа туршид мэргэжлийн чадамжийн стандартад суурилсан багшийн өөрийн үнэлгээг мэргэжлийн тасралтгүй хөгжилтэй уялдуулан хийхэд чухал юм. Загварыг эрдэмтэн судлаачид, мэргэжлийн экспертүүд, багш бэлтгэх их, дээд сургууль, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, төрийн бус байгууллага, багшийн мэргэжлийн бие даасан, нэгдмэл байгууллага, бодлого боловсруулагчид, багш нар хамтран боловсруулж, холбогдох бодлогын баримт бичиг, сургалтын хөтөлбөрт тусган мөрдлөг болгож ажиллана. Энэхүү загвар нь багшийн үнэлгээ, тэр дундаа мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны төлөвлөлтөө өөрийн үнэлгээнд тулгуурлан хийх боломжийг олгоно.

Багш бэлтгэх их, дээд сургуулийн хөтөлбөрийг нэг түвшинд хүргэх, түүний чанар, нийцийг албан ёсоор баталгаажуулах, магадлан итгэмжлэх, чадварлаг багш гэдгийг ижил түвшинд ойлгож хэрэглэх, багш бэлтгэх болон мэргэжлээрээ цаашид хөгжих үйл ажиллагааны ерөнхий хүрээг тодорхойлж, уялдааг нь хангах, багшийн мэргэжлийн нэр хүндийг өсгөх зорилгоор нэгдсэн стандарттай болох, багш бэлтгэх сургалтыг сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын сургалттай уялдуулах, профессор багш нар

---

[6] АХБ, БШУЯ. 2016-2020. ЕБС-ийн 8-12 дугаар ангийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа
[7] БСШУЯ. 2013. Багш боловсролын талаар баримтлах бодлого
[8] "Монголын багш бэлтгэх боловсролын багшийн стандартад хийсэн дүгнэлт" /дунд хугацааны тайлан/ 2014, Багшийн загвар боловсруулах ажлын хэсгийн тайлан. МУБИС. 2014, Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан, 2019, Боловсролын бодлогын судалгаа. БХ, 2020, Монголын багш нарын VII их хурлын эмхтгэл

цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багштай хамтран сургалтын практик болон боловсролын олон талт асуудлаар судалгаа хийж, тулгамдаж буй асуудлыг илрүүлж шийдвэрлэх, харилцан суралцах, судалгааны чадавхыг бэхжүүлэх зэргээр багшийн үйл ажиллагааны талбарыг тэлж, суралцахуй ба багшлахуйн арга зүйн шинэчлэлийг хөгжүүлэх, хамтын ажиллагаа, түншлэлийн соёлд суралцахад дэмжлэг үзүүлэх замаар дээр дурдсан асуудлыг шийдвэрлэх боломжийг олгоно.

Түүнчлэн багш бэлтгэх их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн уялдаа холбоог сайжруулах, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаа, багшийн хөгжилд тулгамдаж буй асуудал, бэрхшээл, шийдлийг тодорхойлох, багш нарын судалгааны арга зүйн чадварыг хөгжүүлэх зорилго бүхий хамтарсан судалгааны тэтгэлэг олгоно. Судалгааны тэтгэлгийн зорилго, чиглэл, оролцогчдын эрх үүрэг, тавигдах шаардлага, сонгон шалгаруулалт, тэтгэлэг олгох үйл ажиллагаа, үр дүнг тодорхойлох, хэрэгжүүлэх, тэтгэлгийн санхүүжилт зэргийг багтаасан “Хамтарсан судалгааны тэтгэлэг олгох журам”-ыг төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулах хэрэгтэй бөгөөд ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгт багш бэлтгэх их, дээд сургуулийн боловсрол судлал, дидактикийн багш нар зочин багшаар ажиллах боломжтой болно. Зочин багшид тавих шаардлага, ажлын зорилго, чиг үүрэг, хийх гол ажлууд, багш бэлтгэх их, дээд сургууль болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүлээх эрх үүрэг зэрэг харилцааг зохицуулсан журмыг боловсруулан төрийн захиргааны төв байгууллагаас баталгаажуулна.

Багш бэлтгэх их, дээд сургуулиуд өөрсдийн төгсөгчид болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш нарыг чадавхжуулах багшийн нээлттэй боловсролын төв байгуулах эрх зүйн орчин бүрдүүлж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох нь багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд чухал юм. Иймээс багшийн нээлттэй боловсролын төвийг багш бэлтгэх голлох их, дээд сургуулийн дэргэд үе шаттайгаар байгуулах шаардлагатай юм. Энэ төвөөр дамжуулан багш нар өөрсдийн хэрэгцээнд суурилсан мэргэжлийн хөгжлийн сургалтад уян хатан байдлаар суралцах, төрөл бүрийн үйл ажиллагаа, тухайлбал бага хурал, эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг зэрэгт нээлттэй оролцох боломжоор хангагдана.

**Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг** боловсролын олон талт үйл ажиллагаанд багш нарыг хамруулж, тэдний чадамжийг хөгжүүлэх насан туршийн суралцах үйл хэмээн тодорхойлдог. Мэргэжлийн тасралтгүй хөгжил хэмээх ойлголт нь *мэргэжлийн* буюу багшид зайлшгүй шаардагдах чадамжийг хөгжүүлэх, туршлага хуримтлуулахад чиглэсэн үйл ажиллагаа[9], *тасралтгүй* буюу насан туршийн мэргэжлийн хөгжил талаас багш нар мэддэг, эсхүл сурсан зүйлийнхээ талаар эргэцүүлэн цаашид ямар чадамж эзэмших хэрэгцээ, шаардлага байгаагаа тодорхойлох, туршин хэрэгжүүлэх циклээр явагддаг үйл, харин *хөгжил* нь дэвшүүлсэн зорилгод хүрсэн, эсвэл шаардлагад хэрхэн нийцэж байгаа байдал бус, харин сурган хүмүүжүүлэх практик үйл ажиллагааг шинэчлэх, хөгжүүлэх талаас ямар үр өгөөжтэй байгаагаар тодорхойлогдох үйл юм.

Багшийн хөгжлийн асуудал нь “мэргэжил дээшлүүлэх”-ээс “мэргэжлийн тасралтгүй хөгжил” рүү хувирч өөрчлөгдөх зайлшгүй шаардлагатай байна. Сүүлийн жилүүдэд боловсролын салбарт хийгдсэн томоохон судалгааны тайлангуудад багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг зөвхөн танхимын сургалтаар тэр дундаа зөвхөн албан журмаар хамруулдаг, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулдаг үндсэн сургалт төдийгөөр ойлгож байгаа[10], мэргэжил дээшлүүлэх сургалтын

[9] үүний нэг салшгүй хэсэг нь үндэсний болоод орон нутгийн түвшинд хэрэгжүүлж буй бодлогын шинэчлэл орн
[10] БСШУСЯ, ДБ, БТДНТ, 2019. СӨБ-ын дэд салбарын дүн шинжилгээ,

агуулга нь багшид мэргэжлээрээ өсөж хөгжихөд шаардлагатай мэдлэг, ур чадварыг олгохгүй байгаа[11], зөвхөн Багшийн мэргэжил дээшлүүлэх институтээс зохион байгуулж буй заавал хамрагдах сургалтууд л мэргэжлийн хөгжлийн сургалтад тооцогддог,[12] хөдөө орон нутгийн багш нар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах боломжоор бүрэн хангагдахгүй байгаа нь сургалтын чанарт нөлөөлдөг[13], 2013 он хүртэл цуглуулсан кредитийг мэргэжлийн зэрэг ахиулах, ажлын үнэлгээнд хэрэглэх боломжтой байсан[14] зэрэг багшийн хөгжлийн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөтэй холбоотой нэлээд асуудлыг хөндсөн байна.

Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил нь цэцэрлэг, сургуульд суурилсан үйл ажиллагааг дэмжсэн, багш, цэцэрлэг, сургуулиас гарсан санаачилгыг дэмжсэн, шинээр сурч мэдсэн зүйлээ турших, хэрэгжүүлэхэд хангалттай хугацаа өгөх, туслалцаа дэмжлэг үзүүлсэн, багш бүрд нээлттэй, хамрагдах боломж бүрдүүлсэн нөхцөлд илүү үр дүнтэй болдог[15]. Иймээс багшийн хөгжих орчныг цэцэрлэг, сургууль гэж үзэх бөгөөд тэднийг ажлын байрандаа хамт олноороо тасралтгүй хөгжих шинэ арга хэлбэрүүд (сургалт, дагалдуулан сургах, хичээлийн ажиглалт, хэлэлцүүлэг, хамтын төлөвлөлт, үнэлгээ, өөрийн үнэлгээ, практик үйлийн судалгаа)-ээр хөгжүүлэхийг зорьж байгаа төдийгүй хөгжих үйл ажиллагаанд мэдээлэл харилцааны технологи ашиглах нөхцөл боломж бий болгох нь энэхүү хөтөлбөрийн чухал зорилтын нэг юм.

Ментор багш[16] нь багшлах, бусад багш, тэр дундаа шинэ, залуу багш нарыг дадлагажуулах, заан сургах буюу коучинг хийх, зөвлөн чиглүүлэх, зөвлөн туслах ба шинэ залуу, туршлага багатай багш ажилдаа дадлагажин дасан зохицох, тэдэнд багшлахуйгаас гадна эерэг харилцаа, хандлага төлөвшүүлж, урам өгч дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахын зэрэгцээ багш ахиц амжилтын өөрийн үнэлгээ хийх, хөгжлийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэхэд нь ганцаарчлан болон жижиг бүлгээр зөвлөн ажиллана. Ментор багш нь зөвлөх зэрэгтэй багш болон үндэсний хэмжээнд хэрэгжсэн болон хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдсэн сургагч багш байх ба арга зүйн чадамж өндөртэй, багш нарт зөвлөн туслах ур чадвар эзэмшсэн цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежер, мөн багш бэлтгэх их, дээд сургуулийн клиник багш мөн ментор багшаар ажиллаж болно. Ментор багшид бусад багш нарыг хэрхэн дадлагажуулан сургах, зөвлөх арга зүйн дэмжлэг шаардлагатай тул үндэсний хэмжээнд тэдний чадавхыг бэхжүүлдэг тогтолцоог бий болгох хэрэгтэй. Ментор багшийн үйл ажиллагаа зөвхөн өөрийн ажиллаж байгаа цэцэрлэг, сургуулиар болон мэргэшлээр хязгаарлагдахгүй байж болно.

Багшийн мэргэжлийн хөгжилд ажлын байрнаас гадуур хамрагдсан сургалтаас илүү сургууль, цэцэрлэг нь мэргэжилтнүүдийн уулзан цуглаж, хамтран суралцдаг талбар (professional learning communities) гэдэг талаас нь харж, энэхүү хандлагын үнэ цэнийг ойлгох парадигмын өөрчлөлт хийх шаардлагатай[17] байгааг анзаарч үзэн энэхүү зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Багш ажлын байрандаа хамтран, харилцан бие биеэ хөгжүүлэх мэргэжлийн тасралтгүй хөгжлийн бүлэг (Professional learning communities), менторинг зэрэг шинэлэг хэлбэрийг нэвтрүүлэх, ментор, чиглүүлэгч багшийг бэлтгэх, энэ чиглэлээр бий болсон туршлагыг түгээхэд анхаарна. Ингэснээр хамт олны өөрсдийн мэргэжлийн хэрэгцээг тодорхойлж, түүнийгээ хамтран

[11] Алсын хараа 2050: Боловсролын салбарт эрх тэгш байдал, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх нь
[12] Монгол Улсын боловсролын асуудал – Боловсролын бодлогын тойм судалгаа, ЮНЕСКО 2019
[13] Алсын хараа 2050: Боловсролын салбарт эрх тэгш байдал, үр ашиг, үр дүнг нэмэгдүүлэх нь,
[14] ЮНЕСКО, 2019, Монгол Улсын боловсролын асуудал – Боловсролын бодлогын тойм судалгаа,
[15] Ц.Бурмаа "Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжил: Олон улсын чиг хандлага, туршлагын харьцуулсан судалгаа" 2013
[16] Ментор гэдэг нь олон улсад нийтлэг ашиглагддаг нэр томъёо бөгөөд цаашид гадаад хамтын ажиллагаа өрнүүлэх, өргөжүүлэх зэрэгт ашиглах үүднээс энэхүү нэр томъёогоор, нийтлэг хэрэглэдэг чиг үүргээр нь хэрэгжүүлнэ.
[17] Боловсролын бодлогын тойм шинжилгээ

шийдвэрлэх, харилцан суралцах практик үйл ажиллагаа нь мэргэшсэн, зөвлөн туслах чадвартай ментор, чиглүүлэгчийн зөвлөгөө, чиглүүлэг, дэмжлэгтэйгээр тасралтгүй хөгжих боломж нээгдэнэ. Энд сургууль, цэцэрлэгийн багш нар өөрсдөө санаачлан, манлайлан хөгжүүлж хэрэгжүүлж буй бүлэг, хамтлаг, клуб, багш нарын боловсруулсан төслүүд байж болно.

Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг нь хамт олны мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг хамтран тодорхойлж, асуудлаа шийдвэрлэх арга замыг бүтээлчээр эрэлхийлэх замаар хамтран хөгжих, арга зүй, сургалтын үйл ажиллагаагаа бүтээлчээр эргэцүүлж санал, зөвлөмж өгдөг, бие биедээ урам өгч сэдэлжүүлдэг багш нарын бүлэг байна. Мэргэжлийн хөгжлийн бүлэг нь багш нар мэргэжлээрээ тасралтгүй хөгжих боломжийг олгохоос гадна сургуульд хамт олонч, хамтран, бие биесээ дэмжин ажилладаг эерэг соёлыг бий болгоно. Бүлгийг бэлтгэгдсэн багш чиглүүлэх бөгөөд чиглүүлэгч нь хамтын, бүтээлч, идэвхтэй эрэл хайгуул хийх, урам өгч сэдэлжүүлэх замаар өөрийгөө болон бусдыг мэргэжлийн хувьд хөгжүүлэх чин эрмэлзэлтэй, бүтээлчээр эргэцүүлэх, санал, зөвлөмж өгөх ур чадвартай, манлайлагч багш байна. Чиглүүлэгч багшид мэргэжлийн зэргийн шаардлага тавигдахгүй, харин бусад багштай хамтран өөрийгөө болон бусад багшаа мэргэжлийн хувьд хөгжүүлэх хүсэл эрмэлзэлтэй цэцэрлэг, сургуулийн багш, захирал, сургалтын менежер, цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч байж болно. Багшийн мэргэжлийн хөгжлийн бүлэг нь сургууль, цэцэрлэгийн Багшийн хөгжлийн төвийг түшиглэн үйл ажиллагаа явуулах ба байршил (сургууль, цэцэрлэг, аймаг, сум, дүүрэг) болон заадаг хичээл, мэргэжлээс хамаарсан олон хэлбэртэй байж болно. Одоогийн сургууль, цэцэрлэгийн “Заах аргын нэгдэл”-ийн үйл ажиллагаанууд, хичээлийн судалгаа зэрэг нь мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд багтах ба багш нарын албан, албан бусаар байдлаар хамтран хөгжиж буй үйл ажиллагааг албан ёсны бүтцэд оруулан гүйцэтгэлийн үнэлгээнд тооцох боломжтой болно.

Цэцэрлэг, сургуулийн багш нарын ажлын байрандаа тасралтгүй хөгжих нөхцөл боломж, дэмжлэгийн тогтолцоог бүрдүүлэхэд тухайн байгууллагын удирдлагаас менежментийн шинэ хандлага, манлайллыг шаардана. Энэ нь цэцэрлэг, сургуулийг багш нарын хөгжих орчин болгон хөгжүүлэх, дэмжих “сургалтын манлайлал (instructional leadership)”-ын шинэлэг арга зам бөгөөд цэцэрлэг, сургуулийн удирдлага нь багш нарын мэргэжлийн тасралгүй хөгжилд арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, багш нарын гүйцэтгэлийг үнэлж, дүгнэх чадавхыг бэхжүүлэхэд чиглэнэ. Цэцэрлэг, сургуулийн удирдлагууд багш нараа удирдан, зохион байгуулах, үнэлэх, бие дааж хөгжих цагийн боломж гаргаж өгөх, цэцэрлэг, ментор сургалт зохион байгуулах, мэргэжлийн хөгжлийг бүлгүүдийн үйл ажиллагааг удирдах, санхүүгийн болон менежментийн дэмжлэг үзүүлэх, үр дүнг тэдний гүйцэтгэлд тусган үнэлж дүгнэх, урамшуулах гэх мэт агуулгаар чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд хамрагдах болно. Үүнээс гадна сургууль, цэцэрлэгийн зөвлөл багшийн тасралтгүй хөгжлийн нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтэд шаардлагатай төсөв, нөөц, удирдлагын дэмжлэг хангалттай байгаа эсэхэд хяналт тавьж, суралцахуйг дэмжсэн манлайллын үйл явцыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллана. Сургуулийн өмнөх боловсрол, бага дунд боловсролын тухай хуулиар[18], сургууль, цэцэрлэгийн зөвлөл дэх эцэг эхийн төлөөллөөр дамжуулан эцэг эхийн оролцоо, хяналт, дэмжлэгийг хангах боломжтой юм.

[18] Хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулан эцэг эхийн төлөөллийг нэмэгдүүлэх саналын дагуу

Багшийн мэргэжлийн хөгжлийн тогтолцооны салшгүй нэг хэсэг нь багш нарын бие даасан байгууллага буюу багшийн мэргэжлийн бие даасан, нэгдмэл байгууллага, холбоод, төрийн бус байгууллага юм. Эдгээр нь мэргэжлийн хараат бус байдлыг дээдэлж, мэргэжлийн хөгжил, мэргэжлийн ёс зүйг тодорхойлоход манлайлах үүрэг бүхий, гишүүдийн эрх, үүргийг зүй зохистой хэрэгжүүлэх хэвтээ удирдлагын тогтолцоотой, үндэсний боловсролын бодлого төлөвлөлт, хэрэгжилтэд манлайлан оролцох мэргэжилтнүүдийн нэгдмэл бүрдэл ашгийн төлөө бус байгууллага юм. Багшийн мэргэжлийн холбоод нь боловсролын зорилготой уялдуулан мэргэжлийн тасралтгүй хөгжлийг манлайлах, нийгэмд багш мэргэжлийн нэр хүндийг өргөх, багш мэргэжлийн ёс зүйн кодыг тогтооход голлох үүрэг гүйцэтгэх, ёс зүйг сахиулах зэргээр багш нар өөрсдийгөө засаглах боломжтой болно.

Багшийн мэргэжлийн хөгжлийн дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Орон нутгийн боловсролын байгууллагын мэргэжилтэн, арга зүйч нь орон нутгийн хэмжээнд ментор багш, БМХБ-ийн чиглүүлэгч багш нарт арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллах ба тэдний тасралтгүй хөгжлийг дэмжих нөхцөлийг бүрдүүлж ажиллана. Түүнчлэн цэцэрлэг, сургуулийн менежментийг хөгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллана.

**Багшийн ажлын нөхцөл, цалин хөлс** чиглэлээр багш өөрөө бие даан мэргэжлээрээ тасралтгүй хөгжих, багш ажилдаа сэтгэл хангалуун байх, ажил мэргэжилдээ дуртай байх, тогтвор суурьшилтай ажиллах, багшийн эрэлтийг хангахад тэдний ажлын байрны нөхцөл, цалин хөлс зэрэг нь чухал хөшүүрэг болдог. Багшлах үйлийн кластерийн тогтолцооны үзэл баримтлалаас[19] авч үзвэл энэ нь багш ажил орох шалгуураас эхлээд, ажлын нөхцөл, ачаалал, стандарт, ажлын байранд тогтвор суурьшилтай ажиллах, багшийн хангалт, цалин хөлс, нийгмийн халамж, хамгаалал, тэтгэвэр тэтгэмж гэсэн цогц бүтэцтэй байх юм.

Багшийн ажлын байрны зураглал нь багшийн бодит ачааллыг тодорхойлох, мэргэжлийн стандартыг боловсруулах, албан тушаалын тодорхойлолт, багшийн ажил ороход тавигдах шаардлагыг цэцэрлэг, сургуулийн бодит орчинд хийж гүйцэтгэдэг ажил, үүрэгтэй уялдуулах, стандартын чадамжид суурилан сонгон шалгаруулах, өөрөөр хэлбэл мерит зарчимд тулгуурлан шударга, ил тодоор сонгон шалгаруулах, багш мэргэжилтэн байх үзэл баримтлалыг тууштай хэрэгжүүлэх боломжтой болно. Ингэснээр багш үндсэн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх, суралцагчдыг хөгжилд ажлын ачаалал, цаг хугацаанд баригдалгүйгээр дэмжлэг үзүүлэх боломжийг мөн олгоно. Нөгөө талаас багшийн ажлын ачааллыг тодорхойлоход тухайн хувь хүний өөрийн болон гэр бүлийн хэрэгцээг мөн харгалзах юм. Олон улсын туршлагаас багшийн ажлын нөхцөлийг багшийн мэргэжлийн бие даасан байгууллагатай зөвшилцдөг байна.

Багшийн ажлын нөхцөлтэй холбоотой өөр нэг чухал асуудал нь ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, түүнийг цалин хөлс, урамшуулалтай уялдуулах явдал юм. Гүйцэтгэлийн үнэлгээ нь багш нарын хамтын ажиллагаа, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, өөрийгөө байнга хөгжүүлж, үндсэн үйл ажиллагааны чанар, үр дүнгээ сайжруулахад дэмжлэг үзүүлдэг[20] байна. Энэ нь багшийн ажлын чиг үүрэг, ачаалалтай нийцсэн, багш хэрэгцээндээ нийцүүлэн мэргэжлээрээ тасралтгүй хөгжих үйл ажиллагаанд хамрагдах, ажлын байрандаа ментор, чиглүүлэгч нар, мэргэжлийн хөгжлийн бүлгүүд хамтран ажиллах, бусад цэцэрлэг, сургуульд сайн туршлагаа хуваалцах боломжийг олгосон, дэмжлэг үзүүлсэн шалгуур үзүүлэлттэй байх юм. Иймээс багш нарын ажлыг төлөвлөх үлгэрчилсэн журмыг тэдний ажлын гүйцэтгэлийн

[19] АХБ, БШУЯ. (2020). СӨБ ба БДБ-ын багш, удирдах ажилтны хөгжлийн бодлого, төлөвлөгөө ба судалгааны зөвлөмжид хийсэн кластер анализын тайлан
[20] БШУЯ. 2020. Хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журмын төсөл

үнэлгээ ба дүгнэн урамшуулах, хариуцлага тооцох журамтай хамтад нь боловсруулж[21] мөрдөх нь чухал байна. Эдгээр нь багшид мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үйл ажиллагааны үр дүнд эзэмшсэн ур чадвараа сургалтын практикт хэрэглэх боломж олгоно.

Энэхүү гүйцэтгэлийн үнэлгээний өөр нэг шинэлэг тал нь багш нарт мэргэжлээрээ тасралтгүй, уян хатан хэлбэрээр хөгжих боломж олгох онооны систем бий болгох явдал бөгөөд энэ нь тэдний мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны үр дүнг баталгаажуулахад голлох үүрэгтэй байна. Багш нар тодорхой шалгуур үзүүлэлтийн дагуу оноо цуглуулах бөгөөд энэ нь багшийн карьерын замналыг босоо болон хэвтээ тэнхлэгт хөгжүүлэхэд чиглэнэ. Хэвтээ тэнхлэгээр карьер хөгжих замнал багш нарт ажил үүргээрээ ялгарах, тухайлбал хөтөлбөр төлөвлөгөө, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, ментор, чиглүүлэгчээр ажиллах, мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулахад нь багш нарт дэмжлэг үзүүлэх, сургуулийн удирдлагын үйл ажиллагаанд оролцох боломж олгоно. Өөрөөр хэлбэл арга зүйч, тэргүүлэх, зөвлөх багшийн мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлт, стандарт шаардлага /мэдлэг, чадвар, хандлага/, онооны систем ашигладаг болно гэсэн үг. Харин босоо тэнхлэгээр карьер хөгжих замнал нь багш нар цэцэрлэг сургуулийн менежер, захирал гэх мэт албан тушаалд ажиллах боломжийг олгоно. Гүйцэтгэлийн үнэлгээнд багштай хамтран ажилладаг бүхий л талууд[22] оролцох ба энд $360^0$ аргачлалыг ашиглах шаардлагатай.

Багш мэргэжлээрээ тасралтгүй үр дүнтэй хөгжиж, сургалтын чанарт ахиц гаргахад өөр нэг чухал үзүүлэлт нь багшийн мэргэжлийн зэрэг бөгөөд түүнд дээр дурдсан үйл ажиллагааг тусган шинэчлэх шаардлага зайлшгүй тулгарна. Цэцэрлэг, сургуулийн багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үйл ажиллагааг манлайлахад зөвлөх болон тэргүүлэх зэрэгтэй багшийн үүрэг чухал байна. Иймээс зөвлөх, тэргүүлэх багш нарын ажлын чиг үүрэг, ачаалалд нь бусад багш нар тэр дундаа залуу багш нарт зөвлөн туслах, чиглүүлэх, хичээлийн ажиглалт хийх, шаардлагатай ур чадварыг эзэмшихэд дэмжих үүргийг тусгах хэрэгтэй.

Багшийн ажиллах нөхцөлтэй салшгүй холбоотой нэг хэсэг нь багшийн хангалттай холбоотой бөгөөд түүнийг цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын тооны өсөлт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийн шинэчлэл, өөрчлөлт, багшлах боловсон хүчний зах зээлийн эрэлттэй нийцүүлэн төлөвлөдөг, удирдаж зохион байгуулах асуудал юм. Үүнд багшийн удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлэх явдал чухал бөгөөд энэ системийг багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт арга зүйн байгууллага эхлэн хөгжүүлж, удирдан чиглүүлдэг байх, цаашдаа боловсролын удирдлага, мэдээллийн системд интеграцчилах шаардлагатай болно.

Багш уян хатан хэлбэрээр мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаа, сургалтад хамрагдахад мэдээлэл харилцаа, технологийн хэрэгсэлтэй, интернэтийн орчин хангагдсан байх шаардлагатай. Ялангуяа орон зай, цаг хугацаанаас үл хамааран онлайн, зайн сургалтын хэлбэрээр мэргэжлийн ур чадвараа сайжруулахад тэдэнд компьютер, скайннер гэх мэт онлайн сургалтын хэрэглэгдэхүүнтэй байх хэрэгтэй.

## ДӨРӨВ. ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТ

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх гурван чиглэлийн хүрээнд нийцүүлэн дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Багш бэлтгэх сургалтыг чанаржуулах чиглэлийн хүрээнд:

[21] АХБ, БШУЯ. (2020). СӨБ ба БДБ-ын багш, удирдах ажилтны хөгжлийн бодлого, төлөвлөгөө ба судалгааны зөвлөмжид хийсэн кластер анализын тайлан
[22] Сургуулийн удирдлага, бусад багш нар, эцэг эх, суралцагч гэх мэт

1.1 Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, түүний чанар, үнэлгээг үндэсний хэмжээнд ижил түвшинд хүргэх;

1.2 Багш бэлтгэх болон ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлэх чиглэлийн хүрээнд:

2.1 Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн олон хувилбарт, уян хатан үйл ажиллагааг нийтлэг болон хувь хүний хэрэгцээний, хандлагын судалгаанд үндэслэн хэрэгжүүлэх;

2.2 Багш нар ажлын байрандаа мэргэжлээрээ тасралтгүй хөгжих нөхцөл бүрдүүлэх;

2.3 Багш нарын мэргэжлийн нэгдмэл байгууллагын бие даасан, хараат бус байдлыг дэмжих;

3. Багшийн ажлын нөхцөл, цалин хөлсийг оновчтой болгох чиглэлийн хүрээнд:

3.1 Багшийн сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох, ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах;

3.2 Багшийн ажлын "гүйцэтгэлд суурилсан цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцох аргачлал" "ажлын гүйцэтгэлд суурилсан урамшуулал олгох аргачлал"-ыг тус тус боловсруулж цалин хөлсний аргачлалыг боловсронгуй болгох;

3.3 Багшлах үйлийн орчныг бэхжүүлэх, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлэх.

## ТАВ. ХЭРЭГЖҮҮЛЭХ ХУГАЦАА

Хөтөлбөрийг 2021-2024 онд хэрэгжүүлнэ.

## ЗУРГАА. ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Зорилт 1.1**-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.1.1 21-р зууны Монгол багшийн загвар боловсруулах, холбогдох бодлогын баримт бичиг, сургалтын хөтөлбөрт мөрдлөг болгох;

1.1.2 "Багш мэргэжил"-ийн стандарт (Teacher qualification standards) боловсруулж, багш бэлтгэх их дээд сургуулиудад нэвтрүүлэх;

1.1.3 Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага боловсруулан, багш бэлтгэх их, дээд сургуулийн хөтөлбөрийг шинэчлэх;

1.1.4 Багш бэлтгэх их, дээд сургуулийн хөтөлбөрийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх;

1.1.5 Багш бэлтгэх их, дээд сургуулийн боловсрол судлал, дидактикийн багш нарыг идэвхтэй сургалтын арга зүй, технологи, үнэлгээний шинэчлэлийн чиглэлээр чадавх бэхжүүлэх сургалт, үйл ажиллагаанд хамруулах.

**Зорилт 1.2**-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1.2.1 Багш бэлтгэх их, дээд сургуулийн дидактикийн багш нарыг цэцэрлэг, ЕБС-д зочин багшаар ажиллуулах;

1.2.2 Багш бэлтгэх их, дээд сургууль болон цэцэрлэг, сургуулийн хамтарсан тэтгэлэгт судалгаа хэрэгжүүлэх;

1.2.3 Багш бэлтгэх их, дээд сургуулийг түшиглэн цэцэрлэг, ЕБС-ийн багшид зориулсан нээлттэй боловсролын төв байгуулах.

**Зорилт 2.1**-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1 Багшийн мэргэжлийн стандартыг (professional standards) боловсруулж, батлуулах, мөрдөх;

2.1.2 Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн журмыг шинэчилж[23], мөрдөх;
2.1.3 Багшийн мэдлэг, ур чадвар, хандлагын судалгааг тогтмолжуулах;
2.1.4 Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулга, хэлбэр, арга замыг багшийн мэргэжлийн стандартад нийцүүлэн шинэчилж хэрэгжүүлэх;
2.1.5 Багшийн мэргэжлийн хөгжлийн "карт" бүхий кредиттэй сургалтыг зохион байгуулах;
2.1.6 1.2.2-т заасан нээлттэй боловсролын төвд түшиглэн багшийн чадамжид суурилсан, модуль сургалтыг хөгжүүлж хэрэгжүүлэх, үр дүнг албажуулах, хүлээн зөвшөөрөх журамтай болох;
2.1.7 Багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтын хөтөлбөрийг батлуулах.

**Зорилт 2.2**-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.2.1 Цэцэрлэг, сургуульд ментор сургалтыг нэвтрүүлэх, ментор багшийг сонгож, чадавхыг тогтмол бэхжүүлдэг тогтолцоо бий болгох;
2.2.2 Цэцэрлэг, сургууль, болон дүүрэг, орон нутгийн түвшний багш мэргэжлийн бүлэг (professional learning community)-ийг хөгжүүлэх үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, чиглүүлэгч багшийг сонгож, чадавхыг бэхжүүлэх;
2.2.3 Цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургуулийн менежментийн чадавхыг бэхжүүлэх;
2.2.4 Хот суурин болон хөдөө орон нутгийн цэцэрлэг, сургуульд багш солилцоог хэрэгжүүлэх;
2.2.5 Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт арга зүйн байгууллага, Боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газрын арга зүйч, судлаач, мэргэжилтнүүд цэцэрлэг, сургуульд тодорхой хугацаанд ажиллаж, багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлдэг тогтолцоотой болох.

**Зорилт 2.3**-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.3.1 Багш нарын мэргэжлийн бие даасан нэгдмэл байгууллагын багштай холбоотой аливаа бодлого, түүний хэрэгжилт, хяналт-шинжилгээ үнэлгээнд оролцох оролцоог дэмжих;
2.3.2 Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үр дүнг албан ёсоор хүлээн зөвшөөрөхөд хамтран ажиллах, хамтын хариуцлагыг бэхжүүлэх.

**Зорилт 3.1**-ийн хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.1.1 Багшийн ажлын байрны зураглал хийж ажлын бодит ачааллыг мэргэжлийн стандарт, албан тушаалын чиг үүрэгтэй уялдуулан зохистой тогтоох;
3.1.2 Багшийг сонгон шалгаруулах нийтлэг журмыг мерит зарчимд тулгуурлан, мэргэжлийн стандарттай нийцүүлэн шинэчилж батлуулах, мөрдөх;
3.1.3 Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг онооны системд шилжүүлж, холбогдох журмыг шинэчлэн батлуулах, мөрдөх;
3.1.4 Багшийн мэргэжлийн зэрэг олгох журмыг шинэчлэн батлуулах, мөрдөх.

**Зорилт 3.2**-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.2.1 Гүйцэтгэлд суурилсан цалин нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцох аргачлал боловсруулах;
3.2.2 Ажлын гүйцэтгэлд суурилан урамшуулал олгох аргачлал боловсруулах, хэрэгжүүлэх;
3.2.3 Багшлах хүний нөөцийн удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлэх.

[23] Сургуульд суурилсан ментор, багш солилцоо, professional learning community, Үндсэн сургалт, карттай сургалтууд орно

**Зорилт 3.3**-ын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

3.3.1 Багшийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл харилцаа, холбооны тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, техник тоног төхөөрөмжийг ашиглах чадварыг нэмэгдүүлэх;

3.3.2 Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сэтгэл зүйч ажиллуулах, сургалтын таатай харилцааны нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

## ДОЛОО. ХҮРЭХ ҮР ДҮН

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр чиглэл тус бүрийн хүрээнд дараах үр дүнд хүрсэн байна.

1. Багш бэлтгэх сургалтыг чанаржуулах, багш бэлтгэх болон ерөнхий боловсролын уялдааг сайжруулах

| 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|
| ✓ ББИДС-иудад мөрдөх багш мэргэшлийн стандарт, Монгол багшийн загвартай болсон байна. | ✓ МУБИС, Ховд их сургууль, Дорнод их сургуулийн хөтөлбөр батлагдсан стандарт, загварт нийцэж, магадлан итгэмжлэгдсэн байна. | ✓ Багш бэлтгэх бусад их, дээд сургуулиудын хөтөлбөр шинэчлэгдэж магадлан итгэмжлэгдсэн байна. | ✓ ББИДС төгсөгчдийн мэдлэг, ур чадвар, хандлага багш мэргэжлийн стандартад нийцсэн байна. |
| ✓ ББИДС болон цэцэрлэг, ЕБС-ийн багш, судлаачдын хамтарсан судалгааг сонгон шалгаруулах шаардлага, санхүүжилтийн эх үүсвэр тодорхой болсон байна. | ✓ 25-аас доошгүй хамтарсан судалгаанд санхүүжилт олгож, нийт багш нарын 15-аас доошгүй хувь судалгаанд оролцсон байна. | ✓ 35-аас доошгүй хамтарсан судалгаанд санхүүжилт олгож, нийт багш нарын 25-аас доошгүй хувь судалгаанд оролцсон байна. | ✓ Төгсөгчдийн цэцэрлэг, ЕБС-ийн сургалтын үйл ажиллагааг чанартай зохион байгуулах чадамж сайжирсан байна. |

2. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлэх

| 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|
| ✓ Багш мэргэжлээрээ уян хатан, хувилбарт хэлбэр бүхий, стандартад суурилсан хөгжих журамтай болсон байна. | ✓ Багш мэргэжлийн стандарттай болсон байна. Стандартад суурилсан өөрийн үнэлгээтэй болсон байна | | |
| | ✓ Багш нар стандартад суурилан өөрийн үнэлгээ хийж хөгжлийн төлөвлөгөөтэй болсон байна. | ✓ Багш нар стандартад суурилан өөрийн үнэлгээ хийж хөгжлийн төлөвлөгөөтэй болсон байна. | ✓ Багш нар өөрийн хэрэгцээнд нийцүүлэн мэргэжлээ тасралтгүй хөгжүүлсэн байна. |
| ✓ Багш нарын тасралтгүй хөгжлийг дэмжих санхүүжилтийн бэлтгэл хангагдсан байна. | ✓ Нийт багш нарт мэргэжлийн хөгжлийн картаар дамжуулан санхүүжилт хийгдсэн байна. | ✓ Нийт багш нарын 60-аас доошгүй хувь картаа ашиглан кредиттэй сургалтад сурсан байна. | ✓ Нийт багш нарын 90-ээс доошгүй хувь картаа ашиглан кредиттэй сургалтад сурсан байна. |

| | | | |
|---|---|---|---|
| | ✓ Багш нар хэрэгцээндээ нийцсэн, мэргэжлийн хөгжлийн баталгаажсан үйл ажиллагаанд хамрагдсан байна. | ✓ Багш нар мэргэжлийн хөгжлийн баталгаажсан үйл ажиллагаанд хамрагдаж, үр дүнгээ хүлээн зөвшөөрүүлсэн байна. | ✓ Багш нарын мэргэжлийн хөгжлийн үр дүнг хүлээн зөвшөөрч, багшийн УМС-д бүртгэлжүүлсэн байна. |
| ✓ Багш нар цэцэрлэг, сургуульд суурилсан, багшийн манлайлал бүхий тасралтгүй хөгжих нөхцөл хангагдсан байна. | ✓ 10 аймаг, 5 дүүргийн цэцэрлэг, ЕБС ментор багштай болж, нийт багш нарын 44.7 орчим хувь ментортой хамтран хөгжих боломж бүрдсэн байна. | ✓ Бүх аймаг, дүүргийн цэцэрлэг, ЕБС ментор багштай болж, багш нар ментортой хамтран хөгжих боломж бүрдсэн байна. | ✓ Цэцэрлэг, ЕБС-д суурилсан багш мэргэжлээ тасралтгүй хөгжүүлэх нөхцөл, боломж бүрэн бүрдсэн байна. |
| | ✓ PCL-үүд байгуулагдаж, чиглүүлэгчтэй болсон, багш нар энэ бүлгийн үйл ажиллагаанд оролцсон байна. | | |
| | ✓ Багш нар “Багшийн нээлттэй боловсролын төв”-ийн үйл ажиллагаанд хамрагдсан байна. | | |

3. Багшийн ажлын нөхцөл, цалин хөлсийг оновчтой болгох

| 2021 | 2022 | 2023 | 2024 |
|---|---|---|---|
| ✓ Багшийн ажлын байрны зураглал хийгдэж үр дүнг танилцуулсан байна. | ✓ Багшийн ажлын ачаалал албан тушаалын чиг үүрэг, мэргэжлийн зэрэгтэй нийцсэн байна. | ✓ Багшийн сургалтын бус ажлын ачаалал багассан, мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдах хугацаа нэмэгдсэн байна. | ✓ Багш нар ажилдаа сэтгэл ханамжтай болсон байна. |
| | ✓ Багшийн гүйцэтгэлийг үнэлэх шалгуур үзүүлэлт, онооны системийг боловсруулсан байна. | ✓ Гүйцэтгэлд суурилсан үнэлгээний журамтай болсон байна. | ✓ Багшийг гүйцэтгэлд суурилан үнэлдэг болсон байна. |
| Багшийн ажлын гүйцэтгэл болон цалин хөлсний хамаарлын судалгаа хийгдсэн байна. | ✓ Гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний эрх зүйн орчин бүрдсэн байна. | ✓ Багшийн гүйцэтгэлд суурилсан урамшууллын журам шинэчлэгдэн батлагдсан байна. | ✓ Багш нар ажлын гүйцэтгэлээрээ цалин, хөлс авдаг болсон байна. |
| Багшийн ажлын нөхцөл, сэтгэл зүйн орчны тандалт хийгдэж шаардлагатай хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төлөвлөлт хийгдсэн байна. | ✓ Багш нарт шаардлагатай МХХТ-ийн тоног төхөөрөмжийн санхүүжилт батлагдсан байна.<br>✓ | ✓ Нийт багш нарын 40-өөс доошгүй хувь МХХТ-ийн тоног төхөөрөмжөөр хангагдсан эсвэл нөхцөл сайжирсан байна. | ✓ Багш нарын МХХТ, тоног төхөөрөмжийн ашиглан онлайн болон зайн үйл ажиллагаанд хамрагдалт нэмэгдсэн байна. |
| | ✓ | ✓ ЕБС-ийн багш нар сэтгэл зүйн | ✓ Багш нарын сэтгэл зүйн орчин сайжирсан байна. |

зөвлөгөө авдаг
болсон байна.

## НАЙМ. ХЭРЭГЖИЛТИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

"Чадварлаг багш" арга хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцан хэрэгжүүлэх бөгөөд төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшил гэх мэт бусад талуудын оролцоог хангаж ажиллана.

**АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**




### *Оролцогч талуудын чиг үүрэг*

1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Бага, дунд боловсролын асуудал хариуцсан нэгж: Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэхэд ерөнхий боловсролын сургуулийн багштай холбоотой асуудлаар төлөвлөлт гаргах, мэргэжил арга зүйн удирдлагаар оролцогч талуудыг хангах, хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох журам боловсруулах, чиглэл өгөх, гаргасан шийдвэрт бодлогын дэмжлэг үзүүлнэ.
2. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Сургуулийн өмнөх боловсролын асуудал хариуцсан нэгж: Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэхэд цэцэрлэг, сургуулийн өмнөх боловсролын багштай холбоотой асуудлаар төлөвлөлт гаргах, мэргэжил арга зүйн удирдлагаар оролцогч талуудыг хангах, хэрэгжилтийг хангах зорилгоор холбогдох журам боловсруулах, чиглэл өгөх, гаргасан шийдвэрт бодлогын дэмжлэг үзүүлнэ.
3. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан нэгж: Чадварлаг багш арга

хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнгийн тайлагналтад дүгнэлт гаргана.

4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан нэгж: Арга хэмжээнд тусгагдсан зорилтууд, тэдгээрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардлагатай төсөв, санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, зарцуулалтад хяналт тавих, дэмжлэг үзүүлнэ.

5. Ажлын хэсэг: Чадварлаг багш арга хэмжээний бэлтгэл хангах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, оролцогч талуудын хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

6. Багшийн мэргэжлийн бие даасан нэгдмэл байгууллага: Энд багшийн мэргэжлийн холбоо, бүлэг, хамтлаг, төрийн бус байгууллагууд орох бөгөөд Чадварлаг багш арга хэмжээний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэхдээ багш мэргэжлийн манлайллыг хангах, нийгэмд багш мэргэжлийн нэр хүндийг өргөх, багшийн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оролцогч талуудын хамтын ажиллагаанд манлайлна. Түүнчлэн

7. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага: Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллагад багшийн тасралтгүй хөгжлийн судалгааны арга зүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх, сургалтын модулийн агуулга, арга зүйг сайжруулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.

8. Боловсролын үнэлгээний байгууллага: Багшийн гүйцэтгэлийн үнэлгээний мэдээллийн сан бүрдүүлэлт, мэдээлэлд шинжилгээ хийхэд арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

9. Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага: Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг үндэсний хэмжээнд удирдан, зохион байгуулах; мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд оролцогч төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, багш нарын бүлэг нөхөрлөл, хамтлаг, төслийн үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулах, бүртгэлжүүлэхэд тэдэнтэй хамтран ажиллах; тасралтгүй хөгжлийн сургалтын модуль боловсруулах байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах; Цахим сургалт эрхлэх байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, багш нарын тасралтгүй хөгжлийн хэрэгцээг оролцогч талуудтай хамтран тодорхойлох, хэрэгцээндээ үндэслэн хөгжихөд багшид нөхцөл боломжийг олгож дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах; багш нарын мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, мөшгөх судалгааг хийх, багшийн гүйцэтгэлийн онооны нэгдсэн сан үүсгэх, багш нарыг тасралтгүй мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлнэ.

10. Аймаг, нийслэлийн боловсролын газар: Чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлэхэд Засаг даргад мэргэжлийн дэмжлэг үзүүлж, багшийн тасралтгүй хөгжлийг хангахтай холбоотой гарсан шийдвэрийн орон нутаг дахь хэрэгжилтийг хангах, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургууль, цэцэрлэгүүдийн ментор, чиглүүлэгч багшийн чадавхыг дээшлүүлэх, орон нутгийн сургууль цэцэрлэгийн удирдлагад багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үйл ажиллагаа, багш солилцоог аймаг, сумдын түвшинд зохион байгуулах, багш нарын мэргэжлийн хөгжлийг бүртгэлжүүлэх, мөшгөх, багшийн тасралтгүй хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх;

11. Багш бэлтгэх их, дээд сургууль: Багш мэргэжлийн хөтөлбөрийг багш бэлтгэх сургалтын жишиг хөтөлбөртэй уялдуулан сайжруулж, багшийн тасралтгүй хөгжлийг хангах нээлттэй, онлайн, зайн сургалтын төвүүдээр дамжуулан модуль сургалтыг хөгжүүлнэ.

12. Иргэний нийгмийн байгууллага: Багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургалтын модуль боловсруулах, хувилбарт сургалтыг зохион байгуулахад Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллагатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлэх, ментор багш, багш мэргэжлийн бүлэг нөхөрлөлийн чиглүүлэгч багш бэлтгэх,

чадавхыг дээшлүүлэх, сургуулийн түвшинд хэрэгжүүлэхэд арга туршлагаа хуваалцах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.

13. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль: Цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлэх нөхцөл бүрдүүлэх, багшийн тасралтгүй хөгжилд тулгуурлан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах хүрээнд тухайн чиглэлээр оролцогч талуудтай хамтран ажиллах, цэцэрлэг, сургуулийн удирдлага сургалтын үйл ажиллагааг чанартай, үр дүнтэй, нийцтэй байхад шаардлагатай сургалтын, багшлах үйл ажиллагааны болон орчин нөхцөл бүрдүүлэх, сайжруулах чиглэлээр чадавхаа бэхжүүлж хэрэгжүүлэх; багшийн мэргэжлийн манлайллыг хангах нөхцөлийг бүрдүүлэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн төлөвлөгөөг цэцэрлэг, сургуулийн түвшинд бүх багшийн оролцоотойгоор төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох үйл явцыг нэвтрүүлэх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

## ЕС. ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ГҮЙЦЭТГЭЛИЙН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

“Чадварлаг багш” арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг холбогдох эрх зүйн баримт бичгийн хүрээнд[24] Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын нэгж (ХШҮДАН)[25] хийнэ. Холбогдох яамд, салбарын донор байгууллага, иргэний нийгмийн байгууллагын гишүүнчлэл бүхий орон нутгийн боловсролын бүлэг (Local Education Group), мэргэжлийн холбоод, сургалтын байгууллага болон мэргэжлийн судлаач, шинжээчдийн төлөөллийн оролцоотойгоор хөндлөнгийн хяналт, үнэлгээг хэрэгжүүлж болно.

Хяналт шинжилгээ үнэлгээний үр дүнг дараах аргачлалаар дүгнэнэ[26]. Үүнд:

- ✓ “үр дүнтэй”-зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь);
- ✓ “тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь);
- ✓ “эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь);
- ✓ “үр дүнгүй”-зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0-30 хүртэл хувь);
- ✓ “үнэлэх боломжгүй”-зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсвэл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон байх.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын манлайлал дор аймаг, нийслэлийн боловсролын газар зохион

[24] Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр үйлийн 21.4-д заасанаар Засгийн газраас баталсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, дүгнэлт гаргах журмыг баримтлах ба Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын зургаадугаар зүйл

[25] Засгийн газрын 2020 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Боловсрол, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын асуудал хариуцсан зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүргийн дагуу

[26] ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын 6.2-т заасны дагуу

байгуулж, хагас жилээр болон бүтэн жилээр 2 удаа тайлагнана. Хяналт-шинжилгээ үнэлгээг хөндлөнгийн экспертүүд, хөгжлийн түнш, иргэний нийгмийн байгууллагыг оролцуулан хийнэ. Хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнг хэлэлцүүлж гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох газар, хэлтэс, албан хаагчид хүргүүлж, биелэлтийг хангуулах ба дараагийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

Үүнээс гадна хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ үнэлгээ хийхэд дараах түүвэр судалгааг нэмж хийх шаардлагатай болно. Үүнд:

- Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээний судалгаа-2 жил тутамд
- Сургууль, цэцэрлэгийн удирдлага, хамт олноос хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа (Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт арга зүйн байгууллагын үйл ажиллагаа болон багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөгчийн чадамжийн талаар нэгдсэн судалгаа)-жил тутам
- Сэтгэл ханамжийн судалгаа (Арга хэмжээний үр шимийг хүртэгч багш нараас)-жил тутам

| ХШҮ-ний төрөл | Давтамж | Зорилго | Агуулга хамрах хүрээ | Хариуцах эзэн | Хэнд тайлагнах |
|---|---|---|---|---|---|
| Явцын дотоод хяналт-шинжилгээ | Хагас жил тутам | Арга хэмжээний хэрэгжилтийг тогтмол удирдлагаар хангахад дэмжлэг үзүүлэх | Нөөц, үйл ажиллагаа | ХШҮДАН | БДБГ, БТГ |
| Жилийн гүйцэтгэлийн үнэлгээ | Жил бүр | Тухайн жилд хэрэгжилтэд тулгарсан бэрхшээлүүдийг тодорхойлох, зорилтуудад хүрэхэд гарсан ахицыг системтэйгээр үнэлэх | Жилийн үйл ажиллагаа, зорилт | ХШҮДАН/ БТГ | Сайд, дэд сайд, ТНБД, хөгжлийн түншүүд, ИНБ-ууд |
| Дунд хугацааны үнэлгээ | 2022/2023 | Хүрсэн үр дүн, тулгарсан бэрхшээлийг нарийвчлан үзэж 2023-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаар шийдвэр гаргах, шаардлагатай бол зорилтуудад өөрчлөлт оруулах | Үр дүн, зорилт | БТГ, БДБГ хөндлөнгийн үнэлгээний мэргэжилтнүүд | Сайд, дэд сайд, ТНБД, хөгжлийн түншүүд, ИНБ-ууд |
| Эцсийн үнэлгээ | 2024 | Эцсийн үр дүн, нөлөө, тэдгээрийн ач холбогдол, үр дүнтэй байдал, үр ашиг болон тогтвортой байдлыг шинжилж бодлогын шинэчлэл, дараагийн үйл ажиллагаанд ашиглах сургамжийг тодорхойлох | Үр дүн, нөлөө | БШУЯ, хөгжлийн түнш, ИНБ-ууд, хөндлөнгийн экспертүүд | Сайд, дэд сайд, ТНБД, Орон нутгийн боловсролын бүлэг |

Хяналт-шинжилгээ, үнэлгээний урт хугацааны үр дүнг дараах шалгуур, үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

| Зорилт | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин |
|---|---|---|---|
| 1.1 | Багш бэлтгэх их, дээд сургуулийн төгсөгчийн чадамжийн талаарх ажил олгогчийн (сургууль, цэцэрлэг) сэтгэл ханамжийн түвшин (хувиар) | байхгүй | 75-аас дээш |
| 1.2 | Зочин багш, хамтарсан судалгааны гэрээний тоо | байхгүй | 470 |
| 2.1 | Багшийн аттестатчлалын үр дүн (хувь) | Тооцох боломжгүй | 70-аас доошгүй |
| | Багшийн нээлттэй боловсролын төвийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдсан багш нарын нийт багшид эзлэх жин | | 90%-ээс доошгүй хувь |
| 2.2 | Ментор багшийн тоо | Байхгүй | 900 |
| | Чиглүүлэгчийн тоо | Байхгүй | 100 |
| | Цэцэрлэг, сургуульд суурилсан мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үйл ажиллагаанд хамрагдсан багшийн эзлэх жин | | 90-ээс доошгүй хувь |
| | Солилцоонд хамрагдсан багшийн тоо | Байхгүй | 500 |
| 3.1 | Багшийн цагийн ачаалал, мэргэжлийн зэргээр | 19/21 бүх багшид ижил | Зөвлөх багш – 12/28, Тэргүүлэх багш 15/25, заах аргач 19/21, зэрэггүй 21/19, 1-2 жил ажиллаж буй залуу багш 14/26 |
| | Тогтвор суурьшилтай ажиллах түвшин (Retention rate) | | 95 хувиас багагүй |
| | Багшийн хомсдолын хувь | 4.1 хувь | 1.8 хувь |
| | Багшийн хөгжлийн мэдээлэл, удирдлагын систем | Байхгүй | Системтэй болсон байна |
| 4.1 | Багшийн дундаж цалин | 903300 | Үндэсний дунджаас 2-3 дахин их |
| 4.2 | Багшийн сэтгэл ханамжийн хувь[27] | Байхгүй | 70-аас дээш |

## АРАВ. АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ТУЛГАРЧ БОЛОХ ЭРСДЭЛ, БУУРУУЛАХ АРГА ЗАМ

Арга хэмжээг хэрэгжүүлэхэд дараах эрсдэлтэй тулгарч болохыг анхаарч, тэдгээрийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга замыг тодорхойлох шаардлагатай. Үүнд:

1. Эдийн засгийн нөхцөл байдал хангалтгүй, тогтворгүй байхаас шалтгаалан боловсролын салбарт хийх төсвийн санхүүжилт хангалтгүй байх;
2. Улс төрийн нөхцөл байдал ойр ойрхон өөрчлөгдөх, засаглалын тогтворгүй байдал;
3. Нийгмийн онцгой нөхцөл байдал, байгалийн гамшиг, КОВИД-19 цар тахлын тархалтаас шалтгаалан хөл хорио тогтоох.

Дээрх нөхцөл байдал арга хэмжээний хэрэгжилтийг удаашруулах эсвэл зогсоож, хүссэн үр дүндээ хүрэхгүй байх эрсдэлийг бий болгоно. Үүнээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулахын тулд дараах арга хэмжээг авах шаардлагатай.

| Эрсдэл | Бууруулах арга хэмжээ | Хариуцах эзэн |
|---|---|---|

[27] Сэтгэл ханамжийн судалгаа хийдэг болох

| | | |
|---|---|---|
| 1. Эдийн засгийн нөхцөл байдал хангалтгүй, тогтворгүй байхаас шалтгаалан боловсролын салбарт хийх төсвийн санхүүжилт хангалтгүй байх | ✓ Хэрэгцээнд суурилсан санхүүжилтийн хатуу зарчмыг хэрэглэх<br>✓ Боловсролын салбарын донор байгууллагатай хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, донор байгууллагын дэмжлэгийг нэмэгдүүлэх<br>✓ Хэрэгцээнд суурилсан хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хэрэгжүүлнэ | БШУЯ-ны БТГ, ЕБГ, СЭЗГ |
| 2. Улс төрийн нөхцөл байдал ойр ойрхон өөрчлөгдөх, засаглалын тогтворгүй байдал | ✓ Холбогдох хуулийг хэрэгжүүлэх<br>✓ Бодлогын залгамж халааг алдагдуулахгүй байх арга хэмжээ авах<br>✓ Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн байгууллага, нэгжээр манлайлуулах,<br>✓ БШУЯ-ны жил бүрийн төлөвлөлтөд хөтөлбөрийн зорилтот үйл ажиллагааг тасралтгүй тусгах | БШУЯ-ны БТГ, ЕБГ, БМДИ, Ажлын хэсэг |
| 3. Нийгмийн онцгой нөхцөл байдал, байгалийн гамшиг, КОВИД-19 цар тахлын тархалтаас шалтгаалан хөл хорио тогтоох | ✓ Төлөвлөгөөнд аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлтэй холбоотой стратегийг нэмж тусгах<br>✓ Нээлттэй, онлайн сургалтын нөөц, эх үүсвэртэй болох | БШУЯ-ны БТГ, ЕБГ |

## АРВАН НЭГ. АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТ

| Зорилт | Үйл ажиллагаа | 2021 | 2022 | 2023 | 2024 | Бүгд |
|---|---|---|---|---|---|---|
| 1.1 | 1.1.1 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 1.1.2 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 1.1.3 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 1.1.4 | - | 254.92 | 254.92 | 254.92 | 764.75 |
| | 1.1.5 | 252.80 | 239.60 | 239.60 | 239.60 | 971.60 |
| 1.1-ийн дүн | | 312.20 | 494.52 | 494.52 | 494.52 | 1,795.75 |
| 1.2 | 1.2.1 | - | 150.50 | 351.00 | 516.65 | 1,018.15 |
| | 1.2.2 | - | 4,560.00 | 4,560.00 | 4,560.00 | 13,680.00 |
| 1.2-ын дүн | | - | 4,710.50 | 4,911.00 | 5,076.65 | 14,698.15 |
| 1-р зорилтын дүн | | 312.20 | 5,205.02 | 5,405.52 | 5,571.17 | 16,493.90 |
| 2.1 | 2.1.1 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 2.1.2 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 2.1.3 | - | - | - | - | - |
| | 2.1.4 | - | 20,799.00 | 20,799.00 | 20,799.00 | 62,397.00 |
| | 2.1.5 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 2.1.6 | - | - | - | - | - |
| 2.1-ийн дүн | | 59.40 | 20,799.00 | 20,799.00 | 20,799.00 | 62,456.40 |
| 2.2 | 2.2.1 | 98.25 | 163.50 | 163.50 | 163.50 | 588.75 |
| | 2.2.2 | 571.16 | 557.96 | 557.96 | 557.96 | 2,245.06 |
| | 2.2.3 | 369.67 | 356.47 | 356.47 | 356.47 | 1,439.10 |
| | 2.2.4 | - | 25.25 | 353.58 | 883.96 | 1,262.79 |
| | 2.2.5 | - | - | - | - | - |
| 2.2-ын дүн | | 1,039.09 | 1,103.19 | 1,431.52 | 1,961.90 | 5,535.69 |
| 2.3 | 2.3.1 | - | - | - | - | - |
| | 2.3.2 | - | - | - | - | - |
| 2.3-ын дүн | | - | - | - | - | - |
| 2-р зорилтын дүн | | 1,098.49 | 21,902.19 | 22,230.52 | 22,760.90 | 67,992.09 |
| 3.1 | 3.1.1 | 119.8 | - | - | - | 119.80 |
| | 3.1.2 | 19.8 | - | - | - | 19.80 |
| | 3.1.3 | 19.8 | - | - | - | 19.80 |
| | 3.1.4 | 19.8 | - | - | - | 19.80 |
| 3.1-ийн дүн | | 179.2 | - | - | - | 179.20 |
| 3.2 | 3.2.1 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 3.2.2 | 19.80 | - | - | - | 19.80 |
| | 3.2.3 | - | 1,290.00 | - | - | 1,290.00 |
| 3.2-ын дүн | | 39.60 | 1,290.00 | - | - | 1,329.60 |
| 3.3 | 3.3.1 | 0 | 3500 | 7000 | 11550 | 22,050.00 |
| | 3.3.2 | 0 | 5109.8827 | 5109.8827 | 5109.8827 | 15,329.65 |
| 3.3-ын дүн | | 0 | 8609.8827 | 12109.883 | 16659.883 | 37,379.65 |
| 3-р зорилтын дүн | | 218.80 | 9,899.88 | 12,109.88 | 16,659.88 | 38,888.45 |
| НИЙТ | | 1,629.49 | 37,007.09 | 39,745.92 | 44,991.95 | 123,374.44 |
| Үүнээс улсын төсвөөс санхүүжих | | | | | | 85,589.69 |
| Төсөл, хөтөлбөрөөс санхүүжүүлэх | | | | | | 37,784.75 |

"Чадварлаг багш" арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааны санхүүжилтийн тооцоог дараах хүснэгтэд харуулав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн тооцоо, сая төгрөг

Хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 4 жилийн хугацаанд нийт 123.4 тэрбум төгрөг шаардагдахаар байгаа бөгөөд хамгийн их санхүүжилт буюу нийт санхүүжилтийн 55.1 хувь нь 2-р зорилт буюу багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаанд шаардлагатай байна. Тэр дундаа карттай сургалтын төсөв хөтөлбөрийн нийт санхүүжилтийн 50 хувьтай тэнцжээ.

Хөтөлбөр, төлөвлөгөө хэрэгжих эхний жилд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр, механизмыг тодорхой болгох үйл ажиллагаанууд хэрэгжихтэй холбоотойгоор бага төсөвтэй (1.6 тэрбум төгрөгийн төсөв шаардагдах) үйл ажиллагаанууд төлөвлөгдсөн. Дараагийн жилүүдэд 37-45 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардагдахаар байна.

Арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн 70 орчим хувийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр тооцсон бол үлдсэн 30 хувь буюу 38 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг олон улсын төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлэх нь зүйтэй. Үүнд нээлттэй боловсролын төвийг бэхжүүлэх, багшлах хүний нөөцийн удирдлага, мэдээллийн системийг хөгжүүлэх, багш нарын мэдээлэл, харилцаа холбооны тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулах зэрэг үйл ажиллагаанууд багтсан тул тус чиглэлээр гадны төсөл хэрэгжүүлэх боломжтой гэж төсөөлсөн. Мөн багш боловсролын хөтөлбөрийг олон улсад магадлан итгэмжлэх зардлыг төсөл, хөтөлбөрөөр санхүүжүүлэхээр тооцов. Улмаар арга хэмжээний хүрээнд төлөвлөгдсөн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг төсөл, хөтөлбөрөөр хэрэгжүүлэх тохиолдолд улсын төсөвт ирэх дарамт багасна.

- - - o O o - - -

Боловсрол, шинжлэх ухааны сайдын
2021 оны 01 дүгээр сарын 14-ны өдрийн
A/07 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

**ЧАДВАРЛАГ БАГШ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**
**/2021-2024 ОН/**

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| 1.1 Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр, түүний чанар, үнэлгээг үндэсний хэмжээнд ижил түвшинд хүргэх | 1.1.1. 21-р зууны Монгол багшийн 4 загвар боловсруулж, түгээн дэлгэрүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх | 21-р зууны Монгол багшийн загвар боловсруулан баталж мөрдүүлэх, ингэхдээ багшийн мэргэжлийн чадамжийг *шинэ багш* болон мэргэжлийн зэрэгтэй (*арга зүйч, тэргүүлэх, зөвлөх*) багшийн хувьд 4 түвшинтэй боловсруулах | ББИДС-иуд Монгол багшийн загварыг холбогдох бодлогын баримт бичиг, сургалтын хөтөлбөрт мөрдлөг болгох | ББИДС-иуд Монгол багшийн загварыг баримт бичигтээ хэрхэн тусгасан талаарх үнэлгээ хийх | Үнэлгээний үр дүнд тулгуурлан ББИДС-иуд Монгол багшийн загвар болон хэрэглээг сайжруулах | БШУЯ, БХ, БМДИ, ББИДС, БШУЯ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| | 1.1.2. Багш мэргэшлийн стандарт (Teacher qualification standards) боловсруулж, ББИДС-д нэвтрүүлэх | Багшийн мэргэшлийн стандартыг боловсруулан баталж ББИДС-д хүргүүлэх, /1 стандарт/ | ББИДС-иуд багшийн мэргэшлийн стандартыг мөрдөн ажиллаж эхлэх, | ББИДС-иуд багшийн мэргэшлийн стандартыг баримт бичигтээ хэрхэн тусгасан талаарх үнэлгээ хийх | Үнэлгээний үр дүнд тулгуурлан ББИДС-иуд багшийн мэргэшлийн стандарт болон хэрэглээг сайжруулах | БШУЯ , БХ, БМДИ, ББИДС, БШУЯ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| | 1.1.3 Багш бэлтгэх хөтөлбөрийн үзэл баримтлал, хөтөлбөрт тавих нийтлэг шаардлага боловсруулж хэрэгжүүлэх | Үнэт зүйл, үр дүн, суралцахуйд суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлал бүхий багш бэлтгэх хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг | МУБИС, МУИС, ХИС, Дорнод, Ховд ИС-ийн багш бэлтгэх хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын дагуу шинэчлэгдэх | Бүх ББИДС-ийн багш хөтөлбөр нийтлэг шаардлагын дагуу шинэчлэгдэж дуусах | ББИДС-иуд хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагыг баримт бичигтээ хэрхэн тусгасан | БШУЯ, БХ, ББИДС |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | | боловсруулах /1 нийтлэг шаардлага/ | | | талаарх үнэлгээ хийх | |
| | 1.1.4 ББИДС-ийн хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх, чиглүүлэх | Багш бэлтгэх хөтөлбөрүүдийг дотоодын болон гадаадын магадлан итгэмжлэлд хамруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан мөрдөж эхлэх, /1 төлөвлөгөө/ | Дотоодод МУБИС, МУИС, ХИС, Дорнод, Ховд ИС-ийн багш бэлтгэх хөтөлбөрүүдийг бүрэн магадлан итгэмжлэлд хамруулах, 5-аас доошгүй хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах | Бусад ББИДС-ийн багш бэлтгэх хөтөлбөрүүдийн 50%-иас доошгүйг дотоодын магадлан итгэмжлэлд хамруулах, 5-аас доошгүй хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх | Бүх ББИДС-ийн хөтөлбөрүүд дотоодод бүрэн магадлан итгэмжлэгдсэн байх, 5 -аас доошгүй хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд хамруулах, хөтөлбөрийн хэрэгжилтэд үнэлгээ хийх | БШУЯ, БМИҮЗ, ББИДС |
| | 1.1.5. ББИДС-ийн боловсрол судлал, дидактикийн багш нарыг идэвхтэй сургалтын арга зүй, шинэлэг сургалтын технологийн чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд хамруулах | ББИДС-ын багш нарыг идэвхтэй сургалтын арга зүй, шинэлэг сургалтын технологийн чадавх бэхжүүлэх сургалтын модуль боловсруулах сургалт зөвлөгөөг зохион байгуулах Модуль боловсруулж эхлэх | ББИДС-иудын боловсрол судлал, дидактикийн багш нарыг идэвхтэй сургалтын арга зүй, сургалтын шинэ технологийн сургалтад хамруулах /30%/ | ББИДС-иудын боловсрол судлал, дидактикийн багш нарыг идэвхтэй сургалтын арга зүй, сургалтын шинэ технологийн сургалтад хамруулах /70%/ | ББИДС-иудын боловсрол судлал, дидактикийн багш нарыг идэвхтэй сургалтын арга зүй, сургалтын шинэ технологийн сургалтад бүрэн хамруулах | ББИДС |
| 1.2 Багш бэлтгэх болон ерөнхий боловсролын сургалтын уялдаа, хамтын ажиллагааг сайжруулах | 1.2.1 ББИДС дидактикийн багшийг ЕБС-д зочин багшаар ажиллуулж, ББИДС болон ЕБС-ийн хамтарсан судалгааны тэтгэлэг хэрэгжүүлэх | ББИДС болон ЕБС-ийн хамтарсан судалгааны тэтгэлгийг үндэсний хэмжээнд олгох журам батлан мөрдөж эхлэх<br>ББИДС-иудын багш нар болон ментор багш нарын судалгааны арга | Боловсролын байгууллагуудаас судалгааны чиглэлийг тодруулан нэгтгэх, төлөвлөгөө гаргах Судалгааны тэтгэлгийн сэдвийг зарлаж, хамтарсан баг шалгаруулах | Цэцэрлэг сургуулийн багш нарт зориулсан судалгааны арга зүйн зөвлөмж гарын авлага боловсруулах 25-аас доошгүй хамтарсан судалгааны төсөлд санхүүжилт олгох, үүнд ЕБС-ийн нийт | Судалгааны тэтгэлгийн гүйцэтгэлийн үр дүнд хяналт үнэлгээ хийж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх 35-аас доошгүй хамтарсан | БШУЯ, БСГ/БХ, ББИДС, ЕБС |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | | зүйг дээшлүүлэх чадавхыг бэхжүүлэх<br><br>Хамтарсан судалгааны санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэх, төлөвлөлт хийх<br><br>ББИДС-ууд зочин багшаар ажиллах журам, зочин багшийн шалгуур, ажлын зураглалыг боловсруулах | 10-аас доошгүй хамтарсан судалгааны төсөлд санхүүжилт олгох, цэцэрлэг сургуулийн нийт багш нарын 5-аас доошгүй хувь судлаачаар хамтран ажиллах<br><br>ЕБС-ийн 15-аас доошгүй хувьд ББИДС-ийн зочин багш ажиллах | багш нарын 10-аас доошгүй хувь судлаачаар хамтран ажиллах<br><br>ЕБС-ийн 30-аас доошгүй хувьд ББИДС-ийн зочин багш ажиллах | судалгааны төсөлд санхүүжилт олгох, үүнд цэцэрлэг, сургуулийн нийт багш нарын 10-аас доошгүй хувь судлаачаар хамтран ажиллах<br><br>ЕБС-ийн 50-аас доошгүй хувьд ББИДС-ийн зочин багш ажиллах | |
| | 1.2.2. ББИДС -ийг түшиглэн багшийн нээлттэй, цахим, зайн боловсролын төв байгуулах | Багшийн нээлттэй боловсролын төв байгуулах эрх зүйн орчин бүрдэж, санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхой болгох<br><br>Багшийн нээлттэй боловсролын төвийн төлөвлөгөө, модуль боловсруулах, батлуулах | МУБИС-ийн дэргэд багшийн нээлттэй боловсролын төв байгуулах, хөрөнгө оруулалт хийх, мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үл ажиллагааг эхлүүлэх<br><br>Багшийн нээлттэй боловсролын төвийн модуль боловсруулах, сайжруулах | Ховд, Дорнод их сургуулийн дэргэд багшийн нээлттэй боловсролын төв байгуулах, үйл ажиллагааг эхлүүлэх,<br><br>Багшийн нээлттэй боловсролын төвийн төлөвлөгөө, модуль боловсруулах, батлуулах, сайжруулах | Шаардлага хангасан хувийн ББИДС-ийн нээлттэй боловсролын төвд үнэлгээ хийж, үйл ажиллагааг эхлүүлэх<br><br>Нийт нээлттэй боловсролын төвүүдэд үнэлгээ хийх, сайжруулах | БШУЯ, ББИДС |
| 2.1 Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн олон хувилбарт, уян | 2.1.1. Багшийн мэргэжлийн стандартыг (professional standards) | Багш мэргэжлийн стандартыг боловсруулах баг бүрдүүлж, стандарт боловсруулах | Стандартыг мөрдөх<br><br>Багш нар өөрийн үнэлгээ хийх | Стандартыг мөрдөх | Стандартыг мөрдөх | БШУЯ, БМДИ, МУБИС, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| хатан үйл ажиллагааг хэрэгжүүлэх | боловсруулж, батлуулах, мөрдөх | Стандартын дагуу багшийн өөрийн үнэлгээний арга хэрэгслийг боловсруулж, баталгаажуулах | | | | |
| | 2.1.2. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн журмыг шинэчилж мөрдөх [28] | Журмыг шинэчилж боловсруулах | Журмыг мөрдөх | Журмын хэрэгжилтэд үнэлгээ хийх | | БШУЯ, БСГ, БМДИ, БШУЯ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| | 2.1.3. Багшийн мэргэжлийн үндсэн сургалтын агуулга, хэлбэр, арга замыг багшийн мэргэжлийн стандартад нийцүүлэн шинэчилж хэрэгжүүлэх | Багшийн мэргэжлийн хөгжлийн үндсэн сургалтыг стандартад нийцүүлэн шинэчлэх, батлуулах | 1, 5, 10, 15 дахь жилдээ ажиллаж буй багш нарт шинэчлэгдсэн үндсэн сургалт зохион байгуулах | 1, 5, 10, 15 дахь жилдээ ажиллаж буй багш нарт шинэчлэгдсэн үндсэн сургалт зохион байгуулах | 1, 5, 10, 15 дахь жилдээ ажиллаж буй багш нарт шинэчлэгдсэн үндсэн сургалт зохион байгуулах | БМДИ, ББИДС-иуд, БМД чиглэлээр сургалт явуулдаг ТББ-ууд, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага |
| | 2.1.4. Багшийн мэргэжлийн хөгжлийн “карт” бүхий кредиттэй сургалтыг зохион байгуулах | Багш нарын “карт”-тай сургалтын санхүүжилтийг төсөвт тусгах | Багш нарын карттай сургалтад санхүүжилт хийгдэх | Багш нар картаар кредиттэй сургалтад хамрагдах | Багш нар картаар кредиттэй сургалтад хамрагдах | БМДИ, БСГ, ББИДС, БМД чиглэлээр төрөлжсөн сургалт явуулдаг ТББ-ууд |
| | 2.1.5. 1.2.2-т заасан нэлттэй боловсролын төвд түшиглэн багшийн стандартын чадамжид суурилсан, модульт | Чадамжид суурилсан, модуль сургалтыг баталгаажуулах, бүртгэх<br><br>Сургалтын үр дүнг албажуулах, хүлээн зөвшөөрөхтэй | Багшийг хөгжүүлэх стандартын чадамжид суурилсан онлайн, зайн, танхимын модуль сургалтын хөтөлбөрийг бүртгэж, баталгаажуулах | Нээлттэй төвүүдэд багшийн хөгжлийн уян хатан, хувилбарт сургалтыг зохион байгуулах, үр дүнг албажуулах хүлээн зөвшөөрөх | Нээлттэй төвүүдэд багшийн хөгжлийн уян хатан, хувилбарт сургалтыг зохион байгуулах, үр | БШУЯ, БМДИ, БСГ, ББИДС |

[28] Сургуульд суурилсан ментор, багш солилцоо, professional learning community, Үндсэн сургалт, карттай сургалтууд орно

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | сургалтыг хөгжүүлж хэрэгжүүлэх, үр дүнг албажуулах, хүлээн зөвшөөрөх журамтай болох | холбоотой зохицуулалтыг бий болгох | | | дүнг албажуулах хүлээн зөвшөөрөх | |
| | 2.1.6.Багшийн мэргэжлийн хөгжлийн сургалтын хөтөлбөрийг баталгаажуулах | Мэргэжлийн хөгжлийн сургалтын хөтөлбөрийг баталгаажуулах зохицуулалтыг бий болгох | Хөтөлбөрийг баталгаажуулж, багшийн хөгжлийн мэдээлэл удирдлагын нэгдсэн системд байршуулж, багшийг мэдээллээр хангах | Хөтөлбөрийн сонголтыг нэмэгдүүлэн баталгаажуулах | Хөтөлбөрийн сонголтыг нэмэгдүүлэн баталгаажуулах, хяналт шинжилгээ хийх, дахин сайжруулах | БШУЯ, БСГ, БМИҮЗ, БМДИ |
| 2.2.<br>Багш сургуульд суурилан мэргэжлээ тасралтгүй хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх | 2.2.1.Сургуульд суурилсан ментор сургалтыг нэвтрүүлэх, ментор багшийн сонгож, чадавхыг тогтмол бэхжүүлдэг тогтолцоог бий болгох | - Ментор багшийн тогтолцооны зураглал гаргах, ментор багшид тавигдах шаардлага боловсруулах<br>- Ментор багшийн үйл ажиллагаа /орон тоог/ холбогдох эрх зүйн баримт бичигт тусгах | - Ментор бэлтгэх сургалтын хөтөлбөр/модуль боловсруулах<br>- Менторын сургалт, хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах<br>- 10 аймаг, 5 дүүрэгт ментор сургалтыг хэрэгжүүлэх | - Ментор багшийн сургалт зохион байгуулах<br>- Ментор багшийн чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах<br>- 6 аймаг, 2 дүүрэгт ментор багшийн үйл ажиллагааг нэвтрүүлэх<br>- Менторын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах зөвлөмж | - Ментор багшийн сургалт зохион байгуулах<br>- Ментор багшийн чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах<br>- Бүх сургууль ментор сургалтыг нэвтрүүлэх<br>- Менторын үйл ажиллагааг үнэлэх, сайжруулах зөвлөмж | БШУЯ, БМДИ, БСГ, ЕБС |
| | 2.2.2 Сургууль, дүүрэг орон нутгийн түвшний багш мэргэжлийн хөгжлийн бүлэг | - БМХБ тогтолцооны зураглал гаргах, чиглүүлэгч багшид тавигдах шаардлага боловсруулах | - БМХБ чиглүүлэгчийн сургалт зохион байгуулах<br>- Чиглүүлэгч багшийг чадавхыг дээшлүүлэх | - БМХБ чиглүүлэгчийн сургалт зохион байгуулах | - БМХБ чиглүүлэгчийн сургалт зохион байгуулах | БШУЯ, БМДИ, БСГ, ЕБС |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | (professional learning community)–ийг хөгжүүлэх үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх, чиглүүлэгч багшийг сонгож, чадавхийг бэхжүүлэх | - БМХБ чиглүүлэгч багшийн үйл ажиллагааг холбогдох эрх зүйн баримт бичигт тусгах<br>- Чиглүүлэгч бэлтгэх сургалтын хөтөлбөр/модуль боловсруулах<br>- Чиглүүлэгчийн сургалт зохион байгуулах 25 ЕБС дээр БМХБ турших | сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах<br>- БМХБ чиглүүлэгчийн туршилтын үйл ажиллагаанд үнэлгээ хийх, сайжруулах50 ЕБС дээр БМХБ нэвтрүүлэх<br>- | - Чиглүүлэгч багшийг чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах<br>- БМХБ чиглүүлэгчийн үйл ажиллагаанд үнэлгээ хийх, сайжруулах<br>- 100 ЕБС дээр БМХБ нэвтрүүлэх | - Чиглүүлэгч багшийг чадавхыг дээшлүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах<br>- БМХБ тогтолцоонд үнэлгээ хийх, сайжруулах150 ЕБС дээр БМХБ нэвтрүүлэх | |
| | 2.2.3. Цэцэрлэг, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих сургуулийн менежментийн чадавх бэхжүүлэх | - Цэцэрлэг, сургуульд суурилсан мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих удирдлагын менежмент модуль боловсруулах<br>- Цэцэрлэг, сургуулийн сургалтын, багшлахуйн, орчны нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах санхүүжилтийг шийдэх<br>- Орон нутгийн түвшний мэргэжлийн тасралгүй хөгжлийн төлөвлөгөө боловсруулах | - Байгууллагын удирдлагын менежментийн сургалтад сургууль цэцэрлэгийн удирдлагуудыг хамруулах<br>- Сургалтын, багшлахуйн орчны нөхцөлийг бүрдүүлэх, сайжруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх | - Байгууллагын удирдлагын менежментийн сургалтад сургууль цэцэрлэгийн удирдлагуудыг хамруулах<br>- Хамт олон ажлын байрандаа тасралтгүй хөгжих нөхцөл, олон хувилбарт дэмжлэгийн тогтолцоо бүрдүүлэх | -Ажлын байрандаа тасралгүй хөгжил нөхцөл, арга хэлбэр, дэмжлэгийн тогтолцоог бэхжүүлэх<br>-Багшийн мэргэжлийн манлайлал<br>-Өөрийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн төлөвлөгөө | БШУЯ, БМДИ, БСГ, ББИДС, ТББ |
| | 2.2.4. Хот болон хөдөө орон нутгийн ЕБС-ийн багш солилцоог хэрэгжүүлэх | - Багш солилцоог хэрэгжүүлэх журам, удирдамж, шалгуурыг боловсруулах, батлуулах<br>- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх | - Багш солилцоог хэрэгжүүлэх нөхцөл, орчин хангагдсан нийслэлийн, аймгийн төвийн, сумын сургуулиудад 80 хүртэлх тооны багшийг багш | Багш солилцоог хэрэгжүүлэх нөхцөл, орчин хангагдсан нийслэлийн, аймгийн төвийн, сумын сургуулиудад 80 хүртэлх тооны багшийг багш | Багш нарын 5-оос доошгүй хувь багш солилцоонд хамрагдах<br><br>Солилцооны хөтөлбөрийн | БСШУЯ, БМДИ,БСГ, ЕБС |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | | төлөвлөгөө боловсруулах<br>- Тухайн орон нутагтаа, эсвэл бүс нутагт хөтөлбөрт хамрагдах багш нарын судалгаа гаргах | солилцоогоор ажиллуулах | солилцоогоор ажиллуулах | үнэлгээ хийх, сайжруулах зөвлөмж | |
| | 2.2.5. БХ, БМДИ, БСГ-ын арга зүйч, судлаач, мэргэжилтнүүд ЕБС-д тодорхой хугацаанд ажиллаж, багш нарын мэргэжлийн тасралтгүй хөгжилд дэмжлэг үзүүлдэг болох | БМДИ, БХ, БСГ-ын ажилтнууд ЕБС дээр ажиллах удирдамж, заавар, төлөвлөлтийг боловсруулах | Хөтөлбөрийн хэрэгжилт, сурах бичгийн чанар зэрэг судалгааны чиглэлээр БХ-ийн судлаачид, заах арга, мэргэжлийн мэдлэг, заах аргын чиглэлээр БМДИ-ийн мэргэжилтнүүд БГ-ын арга зүйч, менторуудтай хамтран ЕБС-д очиж ажиллах | Хөтөлбөрийн хэрэгжилт, сурах бичгийн чанар зэрэг судалгааны чиглэлээр БХ-ийн судлаачид, заах арга, мэргэжлийн мэдлэг, заах аргын чиглэлээр БМДИ-ийн мэргэжилтнүүд БГ-ын арга зүйч, менторуудтай хамтран ЕБС-д очиж ажиллах | Хөтөлбөрийн хэрэгжилт, сурах бичгийн чанар зэрэг судалгааны чиглэлээр БХ-ийн судлаачид, заах арга, мэргэжлийн мэдлэг, заах аргын чиглэлээр БМДИ-ийн мэргэжилтнүүд БГ-ын арга зүйч, менторуудтай хамтран ЕБС-д очиж ажиллах | БСШУЯ, БМДИ,БХ, БСГ, ЕБС |
| 2.3 Багшийн мэргэжлийн бие даасан, хараат бус байдлыг дэмжих | 2.3.1 Багшийн мэргэжлийн бие даасан байгууллагын багштай холбоотой аливаа бодлого, түүний хэрэгжилт, хяналт-шинжилгээ үнэлгээ, баталгаажуулалтад оролцох оролцоог дэмжих | Мэргэжлийн багш нарын холбоодыг нэгдмэл зохион байгуулалтад орж, үйл ажиллагаа эрхлэх талаар эрх зүйн зохицуулалт хийх,<br>Багшийн мэргэжлийн стандарт, гүйцэтгэлд суурилсан үнэлгээний шалгуур үзүүлэлт боловсруулах, ажлын ачаалал, мэргэжлийн зэрэг болон хөтөлбөрийг баталгаажуулах эрх | Багш нарын мэргэжлийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр бодлогоо тодорхойлох, хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах; Багшийн мэргэжлийн бие даасан байгууллагуудын багштай холбоотой аливаа бодлого, түүний хэрэгжилт, хяналт-шинжилгээ үнэлгээнд | Багш нарын их хурлаас багш нарын бие даасан нэгдмэл байгууллагын удирдлагыг сонгуулийн үндсэн дээр бүрдүүлэх Цэцэрлэг, сургууль бүрээс 1-2 багш, аймаг, нийслэлээс цэцэрлэг сургуулийн удирдлага 10 хувиас цөөнгүй оролцуулах, Багш нарын их хурлын санхүүгийн | Багшийн мэргэжлийн бие даасан байгууллагын зүгээс тавьсан асуудлуудын шийдвэрлэгдсэн байдалд үнэлгээ хийж, мэргэжлийн байгууллагад хүргүүлэх Мэргэжлийн хөгжлийн чиглэлээр | БШУЯ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | | зүйн орчныг сайжруулахад мэргэжлийн бие даасан байгууллага оролцох | оролцох оролцоог дэмжих | нөхцөлийг төрөөс дэмжиж, явцыг МХТ ашиглан үндэсний хэмжээнд нээлттэй, бүх багш нарт хүргэх | бодлогын судалгаа хийх, байр суурийн баримт бичиг гаргах; | |
| | 2.3.2. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үр дүнг албажуулах, хүлээн зөвшөөрөхөд хамтран ажиллах, хамтын хариуцлагыг бэхжүүлэх | Хамтран ажиллах санамж бичиг байгуулах Багш мэргэжилтэй холбогдох талуудын уулзалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, хамтын ажиллагааны төлөвлөгөө боловсруулах /50 хүний оролцоотой 2 өдрийн уулзалт хэлэлцүүлэг/ Зөвлөмжийг хүргүүлэх /жилд нэг удаа/ | Багшийн мэргэжлийн ёс зүйн хариуцлагын хороо байгуулан, ёс зүйн дүрмийг сахиулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх Мэргэжил дээшлүүлэх сургалтууд, хөтөлбөр, сурах бичиг, уралдаан тэмцээний чанарын асуудлаар судалгаанд суурилсан санал оруулах эрх зүйн орчны боломжийг бүрдүүлэх | Багш боловсролын хөтөлбөрүүдийг магадлан итгэмжлэх үйл ажиллагааг эрхлэх нөхцөлийг бүрдүүлэхэд санаачилгатай ажиллах, ББИДС-ийн хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарын асуудлаар судалгаанд суурилсан санал оруулах | Багшийн мэргэжлийн бие даасан байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгийн үнэлгээ хийх /БШУЯ/ | БШУЯ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| 3.1 Багшийн сонгон шалгаруулалтыг боловсронгуй болгох, ажлын байрандаа тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлөөр хангах | 3.1.1 Багшийн ажлын байрны зураглал хийж ажлын бодит ачааллыг мэргэжлийн стандарт, албан тушаалын чиг үүрэгтэй уялдуулан зохистой тогтоох | Ажлын байрны зураглал хийх<br>Ажлын байранд хийсэн зураглалын дагуу хийгдэх өөрчлөлтөд бэлтгэх, түүнд шаардагдах санхүүжилтийн тооцоог гарган батлуулах | Ажлын ачааллыг шинэчлэн тогтоосон журам боловсруулах, батлах, мөрдөх | Журам мөрдөх | Журмын хэрэгжилтэд үнэлгээ хийх, сайжруулах | БШУЯ, БХ, БМДИ, ХНХЯ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| | 3.1.2 Багшийг сонгон шалгаруулах нийтлэг журмыг мерит зарчимд тулгуурлан, мэргэжлийн стандарттай | Нийтлэг журмыг шинэчлэх боловсруулах, батлуулах | Сонгон шалгаруулах журмыг хэрэгжүүлэх | Сонгон шалгаруулах журмыг хэрэгжүүлэх | БШУЯ-аас журмын хэрэгжилтийг үнэлэх | БШУЯ, БМДИ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | нийцүүлэн шинэчилж батлуулах, мөрдөх | | | | | |
| | 3.1.3 Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг онооны системд шилжүүлж, холбогдох журмыг шинэчлэн батлуулах, мөрдөх | Багшийн ажлын гүйцэтгэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлийн судалгаа хийх Судалгааны үр дүнд үндэслэн багшийн ажлыг гүйцэтгэлд суурилан үнэлэх шалгуур үзүүлэлтийг боловсруулах, жинг тогтоох, онооны системийг мэргэжлийн зэрэг, карьерын замнал, мэргэжлийн тасралтгүй хөгжилтэй уялдуулан боловсруулах, тэдгээрийг тусган журмыг батлуулах | Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг байгууллагын болон багшийн хөгжлийн төлөвлөгөө, сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журам зэрэг холбогдох баримт бичигт нийцүүлэх, биелэгдэх нөхцөлийг хангах журмыг мөрдөх | Гүйцэтгэлд суурилсан үнэлгээг хэрэгжүүлэх, | БШУЯ-аас журмын хэрэгжилтийг үнэлэх | БШУЯ, БМДИ, БҮТ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| | 3.1.4 Багшийн мэргэжлийн зэрэг олгох журмыг шинэчлэн батлуулах, мөрдөх | Мэргэжлийн зэргийн шалгуур үзүүлэлтийг шинэчлэх, бусад шалгууртай уялдуулах, | Мэргэжлийн зэрэг багшийн ачаалал, гүйцэтгэлийн үнэлгээ, онооны системтэй нийцсэн журам батлах | Багшид шинэ журмын дагуу мэргэжлийн зэрэг олгох | Багшид шинэ журмын дагуу мэргэжлийн зэрэг олгох<br><br>Журмын хэрэгжилтийг үнэлэх | БШУЯ, БМДИ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| 3.2 Багшийн ажлын гүйцэтгэлд суурилсан цалин, урамшууллыг тооцох аргачлалыг боловсронгуй болгох | 3.2.1 Гүйцэтгэлд суурилсан цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс тооцох аргачлалыг боловсруулах | Гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний системийн судалгаа хийх | Гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний аргачлалыг боловсруулах | 3 сайдын хамтарсан тушаал батлагдах | Гүйцэтгэлд суурилсан цалин хөлсний системийг хэрэгжүүлэх | БШУЯ, СЯ, ХНХЯ, Багшийн мэргэжлийн нэгдмэл байгууллага, холбоод |
| | 3.2.2 Ажлын гүйцэтгэлд суурилан урамшуулал олгох | Ажлын гүйцэтгэл, оноожуулалт үр дүнтэй уялдуулан урамшуулал | 2 сайдын хамтарсан тушаалаар журам батлах | Багшид шинэ журмын дагуу урамшуулал олгох | Багшид шинэ журмын дагуу урамшуулал олгох | БШУЯ, СЯ, БШУЯ, Багшийн мэргэжлийн |

| Зорилт | Үйл ажиллагаа | Хэрэгжилт | | | | Хэрэгжилтийг хангах байгууллага, нэгж |
|---|---|---|---|---|---|---|
| | | 2021 | 2022 | 2023 | 2024 | |
| | аргачлалыг боловсруулах | олгох хувилбарыг боловсруулах | | | | нэгдмэл байгууллага, холбоод |
| | 3.2.3 Багшлах хүний нөөцийн удирдлага,мэдээллийн системийг хөгжүүлэх | Багшлах хүний нөөцийн удирдлага,мэдээллийн системийг хөгжүүлэх нэгжийг байгуулах, хөрөнгө оруулалт хийх | Багшлах хүний нөөцийн удирдлага,мэдээллийн системийн багшийн эрэлт, нийлүүлэлт, хомсдол, мэргэжлийн тасралтгүй хөгжил, сонгон шалгаруулалт, карьерын замнал, гүйцэтгэлийн үнэлгээ, оноожуулалтын модулиудыг боловсруулах | | Удирдлага, мэдээллийн системийг ашиглаж эхлэх | БШУЯ, БМДИ, БУМС |
| 3.3 Багшлах үйлийн материаллаг болон сэтгэл зүйн орчныг сайжруулах | 3.3.1 Багшид шаардлагатай МХТ-ийн хангамжийг нэмэгдүүлэх | Багшид шаардлагатай МХТ-ийн тоног төхөөрөмжийн судалгаа хийх | Тоног төхөөрөмж худалдан авах төлөвлөгөө боловсруулж, санхүүжилтийг шийдвэрлэх | Тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж, багш нарт хүргэх | Тоног төхөөрөмжийн худалдан авалт хийж багш нарт хүргэх | БШУЯ, Цэцэрлэг, сургууль |
| | 3.3.2 Сургуулийн сэтгэл зүйч ажиллуулах, багш нарт сэтгэл зүйн зөвлөгөө үзүүлдэг болох | Сургуулийн орон тооны бүтцийг шинэчлэх, сэтгэл зүйчийн цалингийн санг тооцох | Сэтгэл зүйч ажиллах | Сэтгэл зүйч ажиллах | Сэтгэл зүйч ажиллах | БШУЯ, БСГ, ЕБС |

- - -o O o- - -